**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХШҮ-НИЙ ТАЙЛАН**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

**2023 оны 12 дугаар сарын 31** **Номгон**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл | 1.1.1. Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрт илрүүлэг үзлэгийг чанаржуулах | | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь | 60 | Эрүүл мэндийн даатгалын сан 1.066.400.000 | Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд аймгийн хэмжээнд 30852 иргэн буюу 34.4 хувьтай хамрагдсан. Үүнээс Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний нэгжид 18318 буюу 54.8%, Эрүүл мэндийг дэмжих төвөөр 12534 иргэн буюу 22.3 хувьтай хамрагдсан. Өвчлөлийн хувьд 0-17 насныханд шүдний өвчлөл, 18-34 насныханд бөөр шээсний замын эмгэг, 35-45 насны иргэдэд дотоод шүүрлийн эмгэг, 46-64 насны иргэдэд хоол боловсруулах эмгэг, 64-өөс дээш насны иргэдэд, элэг, цөс, нойр болон түрүү булчирхайн эмгэг зонхилон тохиолдож байна. Энэ онд хавдрын 57 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, үүнээс эдийн шинжилгээгээр 28 хавдрын тохиолдлыг илрүүлж, лавлагаа шатлалд илгээж шаардлагатай арга хэмжээ авч ажиллаж байна. Эрт илрүүлэг үзлэгт хэрхэн хамрагдах, ач холбогдлын талаарх мэдээллийг орон нутгийн 3 телевиз, цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд тогтмол хүргэж байна. | 50% |
| 2 | | 1.1.2.. Улсын чанартай автозам бүхий сумдын Эрүүл мэндийн төвийг | | Арга хэмжээний хэрэгжилтий | 60 | Эрүүл мэндийн даатгалын сан 595.120.000 | Улсын чанартай авто зам дагуух Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн их эмч, 2 сувилагчийг яаралтай тусламжийн төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад, Бөмбөгөр, Бууцагаан, Өлзийт сумын эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түшиглэн яаралтай тусламж, осол гэмтлийн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэх баг байгуулж үйл ажиллагааг өргөжүүлэх | | н хувь | | төгрөг | багийг 12 дугаар сарын 04-ний өдөр ЭМГ, Нэгдсэн эмнэлэг хамтран Осол гэмтлийн үед тусламж үзүүлэх чадавхжуулах сургалтад тус тус хамрууллаа. Бөмбөгөр сумын ЭМТ-ийг 2022 онд ДЭМБ-ын санхүүжилтээр 15.0 сая төгрөгийн өртөгтэй яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтран “Осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц менежмент" сэдэвт танхимын сургалтад Бууцагаан сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сувилагч нар хамрагдаж чадавхжсан. Бөмбөгөр сумыг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн багц болон овор хэмжээ бага, хөнгөн, цэнэглэгддэг батарей, принтер бүхий зөөврийн ЭХО-ны комоор хангасан. Тоног төхөөрөмжөөр хангагдсаны үр дүнд алслагдсан бүс нутагт малчны хотонд хэт авиан үзлэг оношилгоог газар дээр нь хийж, дараагийн шатлалын эмнэлэг, эмч рүү шууд илгээх, зөвлөгөө өгөх зэрэг иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан давуу талтай байна. Тус сумдууд 2023 онд нийтдээ 358 (Бөмбөгөр-134, Бууцагаан-224) иргэдэд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлснээс авто зам дагуух осол гэмтлийн дуудлага 77, зам тээврийн ослын 43, бусад шалтгаант осол гэмтлийн 46 тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвөөс 12 иргэн, Бууцагаан сумын эрүүл мэндийн төвөөс 33 иргэнийг 2 дахь шатлалд шилжүүлэн хүргэж, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн. Бөмбөгөр, Бууцагаан, Өлзийт сумдын эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн багт яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалт, амилуулах суурь тусламж, түлэгдэлтийн үеийн яаралтай тусламж үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулж, амилуулах суурь тусламжийн гардан үйлдлийг хүн тус бүрээр хийлгэж, нийт 16 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. | |
| 3 | | 1.1.3. Хүүхдийн шүдний өвчлөлийг | | Төлөвлөгөөний | 100 | | Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдээр эрт илрүүлэг үзлэгт 6-17 насны 12434 (58%) хүүхдийг амны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | буурулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | | хэрэгжилтийн хувь | | | хөндийн үзлэгт хамруулсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд шүдний хувийн хэвшлийн 6 эмнэлэг 2023 онд ерөнхий боловсролын сургуулийн 6-15 насны 812 хүүхдэд үзлэг хийж, өвчлөл илэрсэн 345 хүүхдийг 100 хувь эмчлэн эрүүлжүүлсэн байна. Үзлэг оношилгоонд хамрагдсан хүүхэд багачуудад амны хөндийн эрүүл ахуйг сахих, шүдээ зөв угаах дадлын талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд Баянхонгор сумын 11 цэцэрлэгийн 2004 хүүхдэд үзлэг хийж, 1040 хүүхдэд шүдний өвчлөл илэрсэн бөгөөд эмчилгээ хийлгэх шаардлагатай 172 хүүхдээс 68 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн ба 23 хүүхдэд сувгийн эмчилгээг үргэлжлүүлэн хийж байна. Эрт илрүүлэг үзлэгт 17373 хүүхэд буюу 57 хувьтай хамрагдаж, нийт хүүхдүүдийн 9232 нь буюу 53.2 хувьд нь шүдний өвчлөл илэрсэн. Насны бүлгээр нь авч үзвэл 0-5 нас 3147 (34%), 6-17 нас 6085 (66%) байгаа нь сургуулийн насны хүүхдүүдийн шүдний өвчлөл сургуулийн өмнөх боловсролын насныхантай харьцуулахад 32 хувиар илүү байна. Энэ онд нийт 18648 хүүхэд шүдний тусламж үйлчилгээ авч, илэрсэн шүдний өвчнийг 100 хувь эмчлэн эрүүлжүүлж ажилласан төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай. | |
| 4 | | 1.1.4. Багийн эмч нарын мотоциклийг үе шаттайгаар шинэчлэх | | Мотоциклоор хангагдсан эмчийн тоо | 17 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | Аймгийн хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 33 багийн эмчийн мотоциклийг үе шаттайгаар шинэчилсэн. 2023 онд өмнөх оны үлдэгдэл 46.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ширхэг мотоциклийг Эрүүл мэндийн газрын судалгаанд үндэслэн Баянбулаг, Баянговь, Баянцагаан, Богд, Бөмбөгөр зэрэг 11 сумын 16 багт багийн эмчийн мотоциклийг хүлээлгэн өгч, хөдөөгийн алслагдсан багийн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллалаа. | 94% |
| 5 | | 1.1.5. Анхан шатны эрүүл мэндийн | | Тоног төхөөрөмжий | 85 | Улсын төсөв | Аймгийн 2022 оны Хөгжлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн тоног | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | төвүүдийн лабораторын тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах | | н хангалтын хувь | | | төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар Улсын төсвийн 312.0 сая төгрөг төсөвт тусгагдсанаас нэгжийн үнэ 15.0 сая, нийт үнэ 180.0 сая төгрөгийн өртөгтэй гематлогийн анализаторыг 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвд нийлүүлсэн бол 2023 онд үлдэгдэл санхүүжилт болох 132.0 сая төгрөгийн биохимийн бүрэн автомат 6 ширхэг анализаторыг 2023 оны 07 дугаар сард Баацагаан, Баянлиг, Бууцагаан, Богд, Өлзийт сум, Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлсэн. Анхан шатны лабораторийн хүчин чадлыг сайжруулснаар иргэдийн оношлогоо, шинжилгээний хүлээгдэл чирэгдэл буурч, лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт 85 хувьтай байна. | |
| 6 | | 1.1.6. Шаардлагатай сумдын ЭМТөвийн түргэн тусламжийн автомашиныг парк шинэчлэлт хийх | | Шинэчилсэн автомашины тоо | 3 | Эрүүл мэндийн яамны төсөв | Аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад ашиглагдаж байсан УАЗ пургон, prado-120 маркийн 2 автомашиныг 2023 оны 2 сарын 10-нд Гурванбулаг, Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэн өгснөөр түргэн тусламжийн бэлэн байдлыг хангаж ажилласан. Эрүүл мэндийн сайдын А/236, А/238-р тушаалаар Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баацагаан сумын эрүүл мэндийн төвд нийт 396.6 сая төгрөгийн үнэ бүхий хүнд өвчтөн тээвэрлэх түргэн тусламжийн автомашин хханган нийлүүлэгдсэн. Нэгдсэн эмнэлэгт хуваарилагдан ирсэн Патрол автомашиныг Богд сумын эрүүл мэндийн төвд шилжүүлж, хөдөөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн байдлыг хангасан. Эрүүл мэндийн сайдын “Төсөв баталж, эрх шилжүүлэх” А/403 дугаар тушаалаар Заг, Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвүүдэд УАЗ пургон автомашины нийлүүлэгчээр "ОТТО МИР" ХХК шалгарч, гэрээний дагуу автомашинаа хүлээн авч, бэхэлгээ доторлогоо хийлгэх ажил явагдаж байна. 2023 онд нийт 4 машин авч, шинэчлэл хийгдэж, 2 автомашин балансаас балансад шилжүүлсэн. | 100% |
| 7 | | 1.1.7. "Жаргалтай амьдрал төв"- ийн үйл ажиллагаанд | | Үйлчлүүлэгчийн тоо | 100 | Орон нутгийн төсөв | Жаргалтай амьдрал төвтэй хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулан, Цагдаагийн газар, Жаргалтай амьдрал төв, Нэгдсэн эмнэлгийн уялдаа холбоог сайжруулах асуудлаар 2 удаагийн уулзалт, | 84% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэг үзүүлэх | | | | | хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2023 онд 84 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж, архинд донтох эмгэгээр хүндэрсэн 45 үйлчлүүлэгчийг Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт хэвтүүлэн эмчилсэн. Донтолтын тусламж үйлчилгээний үр дүн 75 хувьтай байна. Тусламж үйлчилгээ авсан иргэдийг Эрүүл мэндийн газраас харьяа өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад авч ажиллаж байна. Тус төвд хэвтэн эмчлүүлэгчийн хоолны чанар хүртээмж, шим тэжээлийн байдал, хоол үйлдвэрлэл,үйлчилгээнд үнэлгээ өгөх, хоол эмчилгээг хослуулах боломж, нөхцөлийг судалж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч байна. 2023 оны 09 дүгээр сарын 12-19-ны өдрүүдэд “Жаргалтай амьдрал” төвийн хэвтэн эмчлүүлэгчдийн 7 хоногийн өглөө, өдөр, оройн хоолны илчлэг, шим тэжээлийн байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээр хоногт олгож буй хоол дунджаар 1346 ккал илчлэгийг хангаж байсан ба энэ нь хоногийн илчлэгийн 56.5 хувь нь хангалтгүй үзүүлэлттэй үнэлэгдэн, зөвлөмж өгч ажилласан. Хэвтэн эмчлүүлсэн иргэдийн ар гэрийн 70 гаруй хүнд архины хор уршиг сэдвээр сэтгэл зүйч М.Хубилай ганцаарчилсан болон танхимын сургалтыг тогтмол зохион байгуулж, зөвлөгөө өгснөөр эмчилгээний үр дүн өндөр хувьтай байна. АА бүлгийн уулзалтыг Галуут, Баянлиг сумдад зохион байгуулж, нийт 11 хүн хамруулж, нөлөөллийн арга хэмжээ явуулсан. Сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний "Жаргалтай амьдрал" төвд нэмэлт санхүүжилт олгох тухай Аймгийн Засаг даргын 2023 оны А/385 дугаар захирамжаар 100.0 сая төгрөгийг олгож, 2023 оны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн, тасралтгүй хэвийн ажилласан. | |
| 8 | | 1.1.8. Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын байрыг шинээр барих | | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 60 | | Нэгдсэн эмнэлгийн 402.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй эмгэг судлалын албаны байрны зураг төсөв хийгдэж, барилгын ажлын төсвийг 2023 оны төсвийн тодотголоор хэлэлцүүлэн батлуулж, энэ онд барилгын суурь тавигдаж барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна. Эмгэг судлалын албаны шинэ | 33% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрны асуудлыг шийдвэрлэснээр стандартад нийцсэн орчин нөхцөлд үйл ажиллагаа явуулах боломж нөхцөл бүрдэж байна. | |
| 9 | | 1.1.9. Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах | | Хэрэгжилтийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Баянхонгор сумын “Оточ номгон” өрхийн Эрүүл мэндийн төвийн 827,752,000 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын тендерт “Базардарь” ХХК шалгарч, барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай явагдаж, улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. Одоогоор тус жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, 7300 хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг ая тухтай орчин нөхцөлд үзүүлж байна. | 100% |
| 10 | | 1.1.10. Галуут сумын Эрүүл мэндийн төвийн хуучин Халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувилалын төв болгох | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Галуут сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын тендерт нийт 325,0 сая төгрөгийн гэрээний дүнгээр “Ар Тээл” ХХК шалгарч, барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж, улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулсан. Тус эмнэлгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах орчин нөхцөл сайжраад байна . | 100% |
| 11 | | 1.1.11. Заг сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Заг сумын эрүүл мэндийн төвийн 2 блок дээврийн засварын гүйцэтгэгчээр “Жаргантайн Хөх Тариа” ХХК шалгарч, нийт 87.0 сая төгрөгийн гэрээний дүнгээр 2 блокын дээврийн засвар, морог, граш, халдвартын тасгийн засварыг хийхээр шалгарч, дээврийн засварыг гүйцэтгэж дууссан. Улсын комисс хүлээн авсан. | 100% |
| 12 | | 1.1.12. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Аймаг сумын төсөв | Шинэжинст сумын эрүүл мэндийн төвийн 437,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй иж бүрэн засварын ажлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн. Энэ онд орон нутгийн сангаас 50.0 сая төгрөг тусгагдаж, дотор засал, хаалга хийгдэхээр ажлын гүйцэтгэл 15 хувьтай байна. | 70% |
| 13 | | 1.1.13. Өлзийт сумын хуучин эмнэлгийн барилгын их засвар | | Засварын ажлын хэрэгжилтийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Өлзийт сумын хуучин эмнэлгийн барилгын их засварын ажлыг “Густокеи” ХХК аймгийн ОНХС-ийн 150.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн, 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулж ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 1.2. Идэвхтэй амьдрал - Чийрэг иргэн | 1.2.1. Монголын хүүхдийн спортын VII наадам зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 1000 | Улсын төсөв-400 сая, орон нутгийн төсөв, хандавлагч байгууллага 504,0 сая төгрөг | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Наадам зохион байгуулах аймаг, хотыг сонгон шалгаруулах эрх олгох” шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж Монголын хүүхдийн спортын зуны VII наадмыг анх удаа орон нутагт буюу Баянхонгор аймагт зохион байгуулах эрхийг авч 2023 оны 06 дугаар сарын 19-29 өдрүүдэд 23 спортын төрлөөр 197 жин, зайд 1500 багц медалийн төлөө 17 спорт заал танхимд 5227 тамирчин өрсөлдөж амжилттай зохион байгуулсан. | 100% |
| 15 | | 1.2.2. Улс тив дэлхийн тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх | | Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо | 6 | Орон нутгийн төсөв | 2022 оны Улсын их баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 6 давж үнэн зоригт харцага, 5 давж өсөх идэр, өрнөн дэлгэрэх чимэг хүртсэн Н.Золбоо, Б.Эрдэнэхүү, 5 давж улсын начин цол хүртсэн Э.Батмагнай, улсын баяр наадамд их насны морь түрүүлүүлсэн С.Энхтөр нарт тус бүр 20.0 сая нийт 80.0 сая төгрөг; - Тайланд улсад зохион байгуулагдсан бодибилдинг фитнесийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон тамирчин Ж.Сарнай, Э.Анхзаяа, Н.Нэмэхбаяр нарт тус бүр 10.000.000 нийт 30.000.000 төгрөгөөр шагнаж урамшууллаа. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас нэгдсэн дүнгээр 110.0 сая төгрөг зарцуулсан. 2023 онд нийт 7 тамирчинд орон нутгаас дэмжлэг үзүүлж урамшуулсан. | 100% |
| 16 | | 1.2.3. Клубуудын улсын аварга шалгаруулах волейболын тэмцээн зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 250 | Орон нутгийн төсөв | Баянхонгор аймагт 2023 оны 02 дугаар сарын 26-03 дугаар сарын 05-ны хооронд клубүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг Усан бассейн спорт цогцолборт зохион байгуулж Улаанбаатар хотын клубүүдээс эрэгтэй 4 , эмэгтэй 6 баг оролцож нийт 160 тамирчид оролцон волейболын спортыг сурталчилсан арга хэмжээ боллоо. | 64% |
| 17 | | 1.2.4. Бууцагаан сумын Баянбүрд багт Спорт заалны барилгын ажил | | Гүйцэтгэлийн хувь | 50 | Орон нутгийн төсөв | Бууцагаан сумын Баянбүрд багт Спорт заалны барилгын угсралтын ажлыг гүйцэтгэгчээр "Оюут хайрга" ХХК хийж гүйцэтгэн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 18 | | 1.2.5. Бөмбөгөр сумын спорт заал | | Гүйцэтгэлийн хувь | 50 | Орон нутгийн төсөв | Бөмбөгөр сумын спорт заал бүхий багийн хөгжлийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Халзан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүхий багийн хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл ажил | | | | | хайрхан" ХХК гэрээ байгуулан угсралтын ажлыг эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Энэ онд батлагдсан төсөвт өртөгийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Тус ажил нь 2024 оны 06 дугаар сард ашиглалтад орно. | |
| 19 | | 1.2.6. Дөвөнтийн заалны их засвар хийх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Дөвөнтийн заалны их засварын ажлын гүйцэтгэгчээр "Буян арвижих од" ХХК шалгарч, 2022 оны их засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны 12 сард улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 20 | | 1.2.7. Номундалай цогцолбор сургуулийн гадна спорт талбай байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | "Баянхонгор-Эко" ХХК тендэрт шалгарч талбайг тэгшлэх, тойрог замыг цутгах, зарим спорт тоглоомын талбайг цутгаж байршуулах ажил хийгдсэн. | 50% |
| 21 | 1.3. Боловсролын чанар хөгжлийн тулгуур | 1.3.1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах | | Бэлтгэгдсэн ажилтны тоо, Ажлын байраар хангагдсан хувь | 400<br>50 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Баянхонгор политехникийн коллежийг 2023 оны 1 дүгээр сард 2,5 жилээр 13 мэргэжлийн 246 суралцагч төгсөж 43.3 хувь нь ажлын байраар хангагдлаа. Үүнээс барилгын салбарт (Барилын өргөгч угсрагч, барилгын засал чимэглэл мужаан, сантехник, цахилгаан) 18.2 хувь, үйлчилгээний салбарт (үсчин, автозасвар, хоол үйлдвэрлэл, ардын хоцлол хөгжим) 19.9 хувь, Хөнгөн үйлдэрлэлийн салбар (оёдол) 5.2 хувь байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээниий газартай хамтран 2023 оны 4-5 дугаар сард 7 мэргэжлээр 45 хоногийн богионо хугацааны сургалтаар 144 хүнийг хөдөлмөр эрхлэх сангаас 28.6 сая төгрөгийн санхүүжилтээр сургаж,76 хувь ажлын байраар хангагдлаа. | 74% |
| 22 | | 1.3.2. Баян-Овоо сумын дотуур байрны их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг “Есөн-Од” ХХК шалгаран 250 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын их засварыг зураг төсөвт заасаны сантехник, өрөөний засал чимэглэл, шалны паркет гадна талын өнгийг будах бохирын цооног зэрэг ажлууд хийгдсэн. Гал тогооны хананы плита наах, хоолны заалны шалны плита наах гадна талын тохижилтын ажил хийгдээгүй байна. | 70% |
| 23 | | 1.3.3. Баянговь сумын сургуулийн | | Засварын ажлын | 70 | Орон нутгийн төсөв | Баянговь сумын сургуулийн 80 хүүхдийн ортой дотуур байрын их засврын ажлыг аймгийн ОНХС-аас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дотуур байрны их засвар | | явц,хувиар | | | 476сая, сумын ОНХС-аас 100 сая төгрөгөөр “Содон сондор” ХХК бүрэн хийж гүйцэтгэн 2023 оны 9 сарын 10-нд улсын комисст хүлээлгэн өгч ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Тохижилт үйлчилгээ хийгдсэнээр 106 хүүхэд ая тухтай орчинд амьдарч байна. | |
| 24 | | 1.3.4. Заг сумын сургуулийн дотуур байрны гадна пасад, дулаалга хийх | | Засварын ажлын явц,хувиар | 100 | Орон нутгийн төсөв | Дотуур байрны их засварын ажилд “Од” констракшин шалгарч гадна пасадын ажил дулаалга хийгдсэн. Засвар ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн. | 100% |
| 25 | | 1.3.5. Галуут сумын Номун элч сургуулийн дотуур байрны засвар | | Засварын ажлын явц,хувиар | 100 | Орон нутгийн төсөв | Аймгийн ОНХС-ийн 50.0 сая төгрөгний санхүүжилтээр дотуур байрны 19 өрөөний шалыг паркетлаж, 2,3-р давхарын коридорын шалны плитаг сольж, угаалгын өрөөний шалыг хуулан шинээр плитан шал хийж, 1-р давхарын үүдний хэсгийн шалыг плитаг чулуун шал болгон засвар хийсэн. Сумын 100 жилийн ойн хандивын хөрөнгөөр 30.0 сая төгрөгөөр 47 өрөөний хаалгыг шинэчлэн сольсон. Засварын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. | 100% |
| 26 | | 1.3.6. Галуут сумын Мандал багийн сургуулийн дотуур байрны засвар | | Засварын ажлын явц,хувиар | 100 | | Хөрөнгийн эх үүсвэргүй тул их засвар хийгдээгүй | 0% |
| 27 | | 1.3.7. Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Богд сумын ЕБС-ийн 320 хүүхдийн хичээлийн байрны гадна пасадны засварыг “Түйн долгио” ХХК 2022 оны 05 дугаар сарын 07-31-ний хооронд хийж гүйцэтгэсэн болно. Тус компани ажлыг маш сайн хийж гүйцэтгэсэн бөгөөд нэмэлтээр цонхны тавцангийн хөмсөг, спорт залны хана болон сендвич хавтан 2-ын хоорондох хэсгийг шавардаж өгсөн. Барилгын гадна пасатны засварын нийт өртөг 158.782.345₮, үүнээс 2022 онд 75.400.000₮ авсан. 2023 онд 83.382.346 төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 2022/11 тоот барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарч хүлээлгэн өгсөн ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 28 | | 1.3.8. Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Хичээлийн хуучин барилгын дээврийн их засварын тендер 2022 оны 03 дугаар сард Баянхонгор аймагт 250,000 сая төгрөгөөр АЛЕГРОТОВЕР ХХК- шалгарч | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | их засварын ажлыг ашиглалтад оруулах | | | | | 2022 оны 03 дугаар сарын 29 ны өдөр АЛЕГРОТОВЕР ХХК гэрээ байгуулж 2022 оны 5 сараас засварын ажил эхэлсэн. Сургуулийн барилгын дээврийн их засварыг АЛЕГРОТОВЕР ХХК нь 100%-ийн гүйцэтгэлтэй 2022 оны 10 дугаар сард хийж дуусган Улсын комисс хүлээн авсан. Дутуу санхүүжидтийг 2023 онд олгосон.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | |
| 29 | | 1.3.9. Жаргалант сумын сургуулийн их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Сургуулийн гал тогоо, агуулахын их засварын ажлыг “Ерөөл нэмэх' ХХК аймгийн Засаг даргын 202248 тоот гэрээнд үндэслэн гүйцэтгэсэн. Ажил гүйцэтгэх явцад захиалагчийн хүсэлтээр сантехник халаалт, бохир усны систем, агааржуулалтын системийн ажлуудыг нэмэлтээр гүйцэтгэсэн. Хаалга цонх солих, хана шалны пильта наах болон бусад дотоод засварын ажлууд хийгдсэн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 30 | | 1.3.10. Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургуульд Лингафонны танхимын тоног төхөөрөмж | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний хичээлийг явуулах Ленгафоны танхимын хөрөнгийг нийлүүлэх тендерийг сумын Засаг даргын Тамгын газар эрх шилжүүлж, сумын Засаг даргын Тамгын газраас тендер шалгаруулалт зарлахад “СүүХүний” ХХК нь шалгаран 2023 оны 8 дугаар сарын 19 нд нийт 26,928,000 (Хорин зургаан сая есөн зуун хорин найман мянга) төгрөгний тоног төхөөрөмжийг нийлүүлснээр англи хэлний кабинетыг тохижуулан сургалтад ашиглаж байна.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 31 | | 1.3.11. Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн их засварын ажлыг ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | “Жаргантайн хөх тариа” ХХК-тай шууд гэрээ байгуулан ажиллаж шал хуулах, хана цэвэрлэх дотор ажил хийгдэж ангиудын шалыг цементлэн хаалга, цонх, цахилгаан, сан техник, гал тогооны агааржуулалт, ариун цэврийн байгууламжийн ажил гадна талбайн тохижолт элсэн тоглоом цэцэрлэгийн урд талын талбайг шинэчилсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 32 | | 1.3.12. Баянхонгор сумын 5,12-р цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэгийн гадна дотор бохир ус, дотор халаалт, цэвэр ус, 12 дугаар цэцэрлэгийн агааржуулалт шинэчлэх засварыг тендерт шалгарсан “Буян Арвижих” ХХК хийж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувь | |
| 33 | | 1.3.13. Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Орон нутгийн хөгжлийн сангаас 290 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын дээвэр, пассатны будаг, хэсэгчилсэн гэрэлтүүлгийн засварын ажлыг “”ЭЛБАТА” ХХК хийж гүйцэтгэж дууссан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 34 | | 1.3.14. Баян-өндөр сумын цэцэрлэгийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Хүүхдийн цэцэрлэгийн дээвэр болон гадна пасадны засварын ажлын БХАБӨНСЗДТГ/202301015 дугаартай тендерт Баянхонгор аймгийн “Буянт хөрст наран” ХХК нь ялж гэрээг сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан ажилласан. Ажил 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 8 сарын 17-ны өдөр хүртэл 100%-ийн гүйцэтгэлтэйгээр сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 35 | | 1.3.15. Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар тохижилт, хүүхдийн тоглоомын талбайн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Цэцэрлэгийн хуучин барилгын засварын ажлыг “Түйн долгио” ХХК нь” 89.729.715 төгрөгийн өртөгтэйгөөр 2023 оны 05 сарын 19 ны өдрөөс эхлэн 30 нийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 36 | | 1.3.16. Ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | | Ариун цэврийн байгууламжийн тоо | 26 | | 2023 оны 3 дугаар ээлжид Богд, Шинэжинст, Хүрээмарал, Гурванбулаг сумдын сургууль цэцэрлэгийн барилгад ариун цэврийн байгууламж барих судалгааны ажил хийгдэн гэрээ байгуулж, 2024 оны 4 дүгээр сард хийж дуусгахаар төлөвлөсөн. 4 дүгээр элжинд орох сургууль цэцэрлэгийн судалгааг хийж тендерийг зарлахаар бэлтгэсэн. Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж буй "Эрдэнэ Монгол" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээнд нийт сургуулийн 71.4 хувь, дотуур байрны 72.7 хувь, хүүхдийн цэцэрлэгийн 88.5 хувь нь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон. | 30% |
| 37 | 1.4. Шинжлэх ухаан | 1.4.1. Шинжлэх ухаан технологийн аймгийн | | Шинэ патент, грантын тоо | 5 | | "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | технологи, инноваци | зөвлөл, судалгааны баг ажиллуулж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ патент, грант олгох | | | | | тухай" 2023 оны А/196 захирамжаар баталж Шинжлэх ухааны технологийн салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан Засаг даргын орлогчоор батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна Ингэний сүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн, Хангайн бүсийн шатанд Өлзийт МСҮТ-ийн Био Эрчим хүчний мод төсөл, Эрүүл хүнс үйлдвэрлэх, органик бордоог хэрэглэх төсөл, Сүү боловсруулах үйлдвэрлэл, Д.Хишигбаярын Олон улсын стандартад нийцсэн хатаах сүүний үйлдвэр тус тус оролцуулах ажилласан улсын уралдаанд шилдэг 9 бүтээлийн нэгээр Баянхонгор аймгийн Өлзийт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн "Шингэн бордоо " төсөл шалгарч 20.0 сая төгрөгийн грант авсан .Аймгийн Төрийн архивын тасаг, Шинжлэх ухааны акедемийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Үндэсний төв архивтай хамтран "Хошуу нуттаг, судлал" цуврал эрдэм шинжилгээний хурлын хүрээнд "Эрдэнэ засгийн хошуу -Заг Байдрагийн хүрэн бэлчирийн түүх, соёлын судалгаа " сэдэвт эрдэм шинжилгээни йбага хурлын зохион байгуулсан. 2023 онд Оюуны өмчийн газраас Баянхонгор аймгийн иргэн хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй 37 патент болон барааны тэмдэгтийн мэдээлэл ирүүлсэн байна. | |
| 38 | | 1.4.2. Хүрэн Бэлчир, Чин сүжигт номун ханы хийд, Хүрээмарал сум дээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | | Жуулчдын тоо | 20000 | Орон нутгийн төсөв | “Эрдэнэзасгийн хошуу- Хүрэн Бэлчир”, “Дашдоо гүнийн хошуу- Чин сүжигт номун ханы хийд”-ийн түүх соёлын судалгаа чиглэлээр Эрдэм шинжилгээний хурлыг Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив, Түүхийн шинжлэх ухааны хүрээлэнтэй хамтран 10 дугаар сард зохион байгуулах, ажлын хэсэг, хөрөнгийн асуудлыг аймгийн Засаг даргын 2023 оны А/194 дүгээр захирамжаар батлуулан, хэрэгжилтийг хангаж, хурлыг 2023 оны 10 дугаар сарын 19-20 өдрүүдэд УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор Улаанбаатар хотод Төрийн ордны Сүхбаатар болон Их эзэн Чингис хааны танхимд амжилттай зохион байгуулсан. Уг цуврал хуралд нийтдээ давхардсан тоогоор 180 гаруй хүн хамрагдаж, 37 эрдэмтэн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судлаач илтгэл тавьж оролцсоноор орон нутгийн 40 орчим түүхэн мэдээлэл тодотгон судлагдаж иргэдэд танилцуулагдсан түүхэн чухал арга хэмжээ боллоо. Аймгийн хэмжээнд нийт 3 томоохон эвент зохион байгуулж 12,000 мянган жуулчид оролцсон | |
| 39 | 1.5. Халамжаас-Хөдөлмөрт | 1.5.1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1310 | Орон нутгийн төсөв | Аймгийн бүтээн байгуулалтын ажлууд буюу ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, хог хаягдал ангилан ялгах, засмал зам дагуух хайрга чулууг түүх, динозавртай паркийн хашааг буулгах зэрэг аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд түр ажлын байранд 1425, байнгын ажлын байранд 567, нийт 1992 иргэн ажлын байраар хангагдсан. | 100% |
| 40 | | 1.5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | | Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | 1800 | | Ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, сурталчлах ажлын хүрээнд 5 арга хэмжээ, 6 сургалт, нийт 11 удаагийн томоохон арга хэмжээ, сургалт зохион байгуулж, 2322 иргэнийг хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 3029 иргэн хамрагдаж 1.668.1 сая төгрөгийг зарцуулж 1751 байнгын болон түр ажлын байр бий болж, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 5.9 хувиар өсөж, ажилгүйдлийн түвшин 2022 онд 15.5 хувь байсан бол 2023 онд 9.5 хувь болж 6 хувиар буурсан. | 100% |
| 41 | | 1.5.3. Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангах | | Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо | 6380 | | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч ажил хөдөлмөр эрхэлдэггүй 4877 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 108, нийт 4985 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 4985 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 3358, хувиараа хөдөлмөр эрхлэгч 968, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 295, оюутан 83, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 108 байна. Сайн дурын даатгалд шинээр 372 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 114 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүнээр буюу 30.6 хувиар өссөн. | |
| 42 | | 1.5.4. Зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах | | Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо | 2500 | | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг зохион байгуулж ажилгүй иргэд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжил сонгоход шаардлагатай ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг зохион байгуулж, ажил мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2322 иргэн /ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээнд 822, бүлгийн хэлбэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээнд 1500/ иргэн хамрагдаж 27.533.300 төгрөг зарцуулсан. Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 12.0 хувиар өссөн. Аж ахуйн нэгж, байгууллагуудтай түншлэлийн холбоо тогтоож 356 аж ахуйн нэгж, ажил олгогчдоос 2050 сул чөлөөтэй ажлын байрны захиалга авч 1992 иргэнийг ажилд зуучлах үйлчилгээнд хамруулснаас байнгын ажлын байранд 567 иргэнийг зуучилж, 14.577.500 төгрөгийг зарцуулсан. Сул чөлөөтэй ажлын байрны захиалга өмнөх оноос 3.3 хувиар, ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо 20.5 хувиар тус тус өссөн. | 100% |
| 43 | | 1.5.5. Нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах | | Цахимжсан хувийн хэргийн тоо | 12877 | | Аймгийн хэмжээний нийт 12851 тэтгэвэр авагчийн цаасан хувийн хэргийг бүрэн цахимжуулсан. Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулахад Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 7.5 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 44 | | 1.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл,Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс,Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хөдөлмөрийн | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжихэд 9.0 сая төгрөг батлуулж, дэмжиж ажилласан. Салбар зөвлөл болон комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 98.0 хувьтай. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл, Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг дэмжих | | | | | | |
| 45 | | 1.5.7. "Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааг дэмжих | | Үйлчлүүлэгчдийн тоо | 800 | | Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааг явуулахад 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 120.0 төгрөгийн дэмжлэг үзүүлж, хэвийн ажиллагааг нь хангасан. Тус ордонд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх 17 газар үйл ажиллагаагаа явуулж, давхардсан тоогоор 683 иргэн эрүүл мэндийн болон сэтгэл засал, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ авсан. | 85% |
| 46 | 1.6. Соёлтой иргэн-Нийгмийг түгчээлнэ | 1.6.1. Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 200 | | Уртын дууч Ч.Намжилын нэрэмжит уртын дууны улсын уралдааныг аймагт зохион байгуулж аймгаас 16 оролцогчийг хамруулан төв халхын уртын дууг сурталчилсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 72 хүний бүрэлдэхүүнтэй оролцсоноос 44 соёлын өв тээгч, уран бүтээлчид 7 ай савын хүрээнд өв соёлоо сурталчлан шилдгийн шилдгээр шалгарч, “Алтан цом” батламж гардан авсан. .Түүхийн дурсгалт газар, түүхийн болон байгалийн үнэт олдвор нээж илрүүлэх зорилготой аймгийн Засаг даргын 2023 оны 355 дугаар захирамжаар томилогдсон “Хээрийн судалгаа шинжилгээ хайгуул хийх ажлын хэсэг”-ийн ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. “Соёлын бүтээлч сар аян”-ы хүрээнд Соёл урлагийн газар болон соёл урлагийн 23 байгууллага Хөгжимт драмын театр, Тэмүжин театр, Нийтийн номын сан, Түүх угсаатны зүй байгалийн түүхийн музей, 19 сумын Соёлын төвөөс нийт 120 арга хэмжээг зохион байгуулж 21608 хүнд хүрч үйлчилснээс 12102 хүүхэд, 222 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд соёл урлагийн олон талт арга хэмжээг хүргэн ажилласан байна. Зохион | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулагдсан арга хэмжээг төрлөөр ангилбал соён гэгээрэл, мэдлэг түгээх сургалт арга хэмжээ 17, Урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээ 41, Бүтээлч залуусыг дэмжих уралдаан тэмцээн 39, Музей галерейн үзэсгэлэн 23 арга хэмжээг тус тус зохион байгуулав. | |
| 47 | | 1.6.2. Аймгийн зохиолчдын "Хонгорын дуун" утга зохиолын өдөрлөг зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 112 | | Баянхонгор аймгийн Баацагаан сумын уугуул Төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит “Хүрэн морь” яруу найргийн наадам хүүхдийн Тэмүжин театрт “Хонгорын дуун” нэртэйгээр амжилттай зохион байгуулагдаж, Улаанбаатар, Баянхонгор, Ховд, Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Дархан-Уул, Булган, Архангай, Төв аймаг зэрэг 10 аймгаас 61 яруу найрагч оролцож тэргүүн байранд Ховд аймгийн Мянгад сумын харьяат Ц.Отгонбаатар, дэд байранд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын яруу найрагч Т.Эрдэнэчулуун, гутгаар байранд Баянхонгор аймгийн Жаргалант сумын яруу найрагч М.Санжнамжил, дөрөвдүгээр байранд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын яруу найрагч Б.Төгөлдөр, 5-р байранд Дархан-Уул аймгийн яруу найрагч Т.Банзрагч, тусгай байранд Улаанбаатар хотоос оролцогч А.Анхбаатар, Завхан аймгийн яруу найрагч На.Пүрэв-Очир, Улаанбаатар хотоос оролцогч Ж.Цэрэннадмид нар шалгарлаа. Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгууллаа. | 55% |
| 48 | | 1.6.3. Заг Байдрагийн Хүрэн Бэлчирт Монгол туургатны харвуул их наадам зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 300.0 | | “Заг, Байдрагийн хүрэн бэлчир-2023” Монгол туургатны харвуул их наадам 2023 оны 07 дугаар сарын 19-21 өдрүүдэд Заг сумын нутаг Хүрэн бэлчир хэмээх газарт амжилттай зохион байгуулагдаж, Монгол улсын 14 аймгаас давхардсан тоогоор 780 гаруй харваачид, ОХУ-ын Буриад улсаас 3, ӨМӨЗО-ны 10 харваач Үндэсний сурын харваа, Уламжлалт /зэвт/ харваа, Сарамбай харваа, Бөмбөг намнах харваа, Холч харваа зэрэг нийт 6 төрлийн харвааны төрлөөр оролцов. Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 30.0 сая, хандив тусламжаар 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэв. | |
| 49 | | 1.6.4. Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг шинэчлэх | | Тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь | 100 | Орон нутгийн хөгжлийн сан | Аймгийн Хөгжимт драмын театрын 49.0 сая төгрөгийн 9 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж тоног төхөөрөмжийн хангалт 60 хувьтай. Тэмүжин театрын 47.0 сая төгрөгийн театрын зориулалттай 300 ширхэг үзэгчдийн сандал нийлүүлж, тоног төхөөрөмжийн хангалт 50 хувьтай. | 55% |
| 50 | | 1.6.5. Баацагаан сумын соёлын төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Баацагаан сумын Соёлын төвийн ОНХС-ийн 80.0 сая төгрөгийн төсөвтэй засварын ажлыг гүйцэтгэх тендерт Могойн Хөндий ХХК шалгарч 100 хувь гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. | 100% |
| 51 | | 1.6.6. Баянлиг сумын соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж | | 0 | 100 | | Баянлиг сумын соёлын төвд Чүгма Далай ХХК 20.0 сая төгрөгийн 13 төрлийн техник хэрэгслийг нийлүүлж иргэдэд соёлын үйлчилгээг хүргэх таатай нөхцөл бүрдсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 52 | | 1.6.7. Баянлиг сумын соёл төвд шаардлагатай техник хэрэгсэл | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Дэвших- Болор ХХК 20.0 сая төгрөгийн 13 төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлж иргэдэд соёлын үйлчилгээг хүргэх таатай нөхцөл бүрдсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 53 | | 1.6.8. Хүрээмарал сумын соёлын төвд шаардлагатай техник хэрэгсэл | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Хүрээмарал сумын соёлын төвд Чүгма Далай ХХК нь гэрээгээр 20.0 сая төгрөгийн техник хэрэгсэл нийлүүлж соёлын үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 54 | | 1.6.9. Хүрээмарал сумын соёлын төвд шаардлагатай тоног төхөөрөмж | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Дэвших болор ХХК нь гэрээ байгуулан 20.0 сая төгрөгийн 7 төрлийн техник хэрэгсэл, 250 үзэгчийн сандал нийлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 55 | 1.7. Хонгорын иргэн- Хонгорын баялаг | 1.7.1. Аймгийн Хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | | Чуулганаас гарсан саналын шийдвэрлэлтийн хувь | 90 | Байгууллагын төсөв 16,0 сая төгрөг | Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг "Оролцъё-Хөгжье-Хамгаалагдъя" уриан дор 2023 оны 11 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хүүхдийн нэгдсэн чуулганд 18 сумын 30 ерөнхий боловсролын сургуулийн нийт 260 хүүхэд, 37 үүрэг хүлээгчид оролцсон. Чуулган зохион байгуулсны үр дүнд хүүхэд нийгмийн амьдралд оролцох, хөгжих эрхээ хэрэгжүүлэн, хүүхэд бүрийн оролцоог хангаж ажилласан төдийгүй хүүхдүүд орчин тойрондоо | 78% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тулгамдаж буй асуудлаа тодорхойлон шийдвэр гаргагч түвшний хүмүүст хандан асуудал шийдлийн талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн. Чуулганы төлөөлөгч хүүхдүүдээс гарсан 34 саналыг шийдвэр гаргагч түвшний хүмүүс сонсож 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой асуудлуудыг шийдвэрлэхээ илэрхийлсэн. 2022 оны чуулганаас гарсан саналын шийдвэрлэлт 70 хувьтай. 2023 оны чуулганаас гарсан саналын шийдвэрлэлтийн хувь хүлээгдэж байна. | |
| 56 | | 1.7.2. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх | | Угийн бичиг хөтлөлтийн хувь | 10 | Орон нутгийн төсөв | Соёл урлагийн байгууллагуудаас соёлын баримтат өвийг бий болгох, угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 28 арга хэмжээ зохион байгуулан ажиллаж аймгийн хэмжээнд 6731 өрх угийн бичиг хөтөлдөг, шинээр 435 өрх хөтөлж эхэлсэн, угийн бичиг хөтлөх сургалтад 2388 иргэнийг хамруулж угийн бичиг хөтлөлтийг 3.9 хувиар нэмэгдүүлэн 25.1%-д хүргэсэн. НБХ, Угийн бичиг хөтлөлтийн “Хонгор холбоо” Төрийн бус байгууллагатай хамтран Баянхонгор аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын алба хаагчдад угийн бичиг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулж суурь түвшний судалгаа гаргаж явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна | 90% |
| 57 | | 1.7.3. Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжих | | Үйлчлүүлэгчдийн тоо | 200 | Байгууллагын төсөв | "Хуримын ордон" ашиглалтад орж "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийг байгуулж, MNS 6417:2013 стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Зөвлөгөө өгөх төвд ЗГХА-ГБХЗХГ-аас 25.405.000 төгрөгийн санхүүжилтээр стандартын дагуу техник, тоног төхөөрөмжүүдийг авсан. Зөвлөгөө өгөх төвөөр 115 насанд хүрэгч, 68 хүүхэд, 12 гэр бүл / хүйсээр ангилвал 77 эрэгтэй, 124 эмэгтэй/ нийт 201 хүн үйлчлүүлж ганцаарчилсан болон хосын сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авсан байна. Зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийн 12 хүнийг өмгөөллийн үйлчилгээнд, 14 хүнийг түр хамгаалах байранд, 1 хүнийг Өвөрхангай аймгийн ГБХЗХГ-т, 28 хүнийг сумдын хамтарсан багуудад холбон зуучилсан. Зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх дэвтэр нээн тогтмол | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүртгэж байна.Богд, Баянбулаг сумдын аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн дэмжлэгээр зөвлөгөө өгөх зан үйлийн төвийг байгуулах ажил эхэлсэн. | |
| 58 | | 1.7.4. "Өвгөнжаргалант" зусланг түшиглэн амьдрах ухаан, хөдөлмөр зусланг бий болгох | | Зуслан ажиллуулсан сумын тоо | 3 | | Хөдөлмөр зусланг 2023 онд Богд сумд ажиллуулж 14 хүүхэд хамрагдсан. Хөдөлмөр зусланг байгуулснаар хүүхэд, өсвөр үеийнхэн Монгол ёс заншил уламжлалт арга ухаан, үнээ саах, ямаа саах, тараг бүрэх зэрэг мал аж ахуй тэр дундаа сүү цагаан идээ боловсруулах, сур элдэх, түлш түлээ, хоол хүнсээ бэлтгэх зэргээр амьдрах ухаанд суралцсан. Бусад сумдад Хөдөлмөр зусланг ажлуулах боломж хомс байгаа тул Өвгөнжаргалант зусланд зохион байгуулсан Хөдөлмөр зуслангийн ээлжид Бөмбөгөр, Баацагаан, Бууцагаан, Заг, Эрдэнэцогт, Баян-Өндөр, Баянхонгор сумын нийт 30 хүүхэд хамрагдсан. Тайлант онд 1 сум хөдөлмөр зуслангийн үйл ажиллагааг эхлүүлсэн, бусад сумдад ажиллуулах бааз суурь, хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүй байна. | 33% |
| 59 | | 1.7.5. Алслагдсан сум, багийн малчдад зориулсан соёл хүмүүжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулах | | Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо | 10 | | Аймгийн 19 сумын соёлын төв, мэргэжлийн урлагийн 2 байгууллага нь 2023 онд 57 уран бүтээл, 69 урлагийн үйлчилгээг 19 сумын 40 багт хүрч үйлчилж 11634 хүнийг хамруулан 4,2 төгрөгийг зарцууллаа. “Эрдэнэт сүргийн эзэд-1000” малчдын чуулганыг 09 дүгээр сарын 22-24 өдрүүдэд зохион байгуулж Аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчид соёл урлагийн үйлчилгээ үзүүлж, 20 сумдын малчдын урлагийн арга хэмжээг зохион байгуулж Гала тоглолтод шалгарсан урлагийн төрлөөр шоу тоглолт зохион байгууллаа. -Илтгэгч Ж.Баясгалан, Э.Мөнхтуяа нарын “Мөрөөдөл мөхөхгүй” лекцийг Хүүхдийн Тэмүжин театрт 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2 ээлжээр зохион байгуулж малчдыг хамрууллаа. | 100% |
| ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 60 | 2.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, | 2.1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд | | Төлбөрийн баримт олголтын хувь | 90 | Орон нутгийн төсөв | Аймагт худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж, иргэдийн нэгдсэн судалгааг сум тус бүрээр нарийвчлан гаргаж, мэдээллийг шинэчлэн ажилласан. Бүртгэлтэй ААН, иргэдийг сегментээр ангилж, НӨАТ-ын тухай хуулийн танхимын 16, цахим | 55% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна. | татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90-ээс дээш хувьд хүргэх | | | | | 14 удаагийн сургалтад 1116 татвар төлөгчийг хамрууллаа. “Энд төлбөрийн баримт олгоно” наалтыг 1500 ширхэг, нэмэгдсэн өртгийн албан татвар” нэртэй, 18 хуудас бүхий гарын авлага хэвлэж, 350 ширхгийг тус тус бэлтгэж 19 суманд үйл ажиллагаа явуулж байгаа цэгүүдэд байршуулж мэдээлэл хүргэсэн. НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор 19 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зах худалдааны төв, дэлгүүр болон бусад худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжийн дагуу хяналт шалгалтыг, Мөн аймгийн Прокурорын газартай хамтран Баянхонгор суманд 03 дугаар сард хамтарсан хяналт шалгалтын тус тус хэрэгжүүлж, 45 объектод шалгалт хийж 17 зөрчил илрүүлж, 7 иргэнд 4.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан. И-баримт аппликейшн болон 1800-1288 дугаарын утсаар 313 гомдол, мэдээллээс 299 гомдлыг барагдуулж, хариу өгсөн, 14 гомдол хүлээгдэж байна. Гомдол мэдээллийн дагуу иргэдэд төлбөрийн баримтыг нөхөн олгуулж, 56 татвар төлөгчид мэдэгдэл, 22 татвар төлөгчид шаардлага өгч, зөрчлийг давтсан 9 татвар төлөгчид 3.1 сая төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгууллаа. Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 4520 цэгт худалдаа үйлчилгээ эрхлэж байгаагаас 3561 цэгт И-баримт олгож байгаа буюу нийт татвар төлөгчдийн 78.8 хувь нь И-баримт олгож, 2023 онд байдлаар 16.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 2,458,721 ширхэг баримт хэвлэгдэж, 2489 азтан тодорсон байна. | |
| 61 | | 2.1.2. Санхүүгийн эрсдэл бүхий 2 байгууллагад дотоод аудит, 4 суманд Аймгийн Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах ажлыг зохион байгуулах | | Эрсдэл өндөртэй байгууллагын тоо | 18 | | Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу Дотоод аудитын эрсдэлийн үнэлгээг хийж Хүүхдийн Тэмүжин театрын үйл ажиллагаа, нийт 20 сумын Засаг даргын Тамгын газрын шатах, тослох материалын зардалд дотоод аудитыг хийж зөвлөмжийг хүргүүлсэн. Эрсдэл өндөртэй байгууллагын тоог 2 байгууллагаар бууруулсан. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн хяналт шалгалт, санхүүгийн үзлэгийг Хүрээмарал, Заг, Галуут, Гурванбулаг сумдын төсөвт байгууллагуудын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэж, нийт 468,263,786 төгрөгийн зөрчил илрүүлж 104,503,929 төгрөгийн албан шаардлага бичиж, 35,580,514 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 328,179,343 төгрөгийн зөвлөмж өгч, санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг 25 хувиар бууруулан, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Хөдөө 4 сумын 24 байгууллагад санхүүгийн нэгдсэн хяналт шалгалт, үзлэгийг зохион байгуулж, төсвийн үр ашгийг 35,580,514 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Санхүүгийн эрсдэл бүхий 2 байгууллагад дотоод аудит, 4 суманд аймгийн Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах ажлыг зохион байгуулж эрсдэлтэй байгууллагын тоог 16 болгож бууруулан зорилтод түвшинд хүргэн ажилласан байна. | |
| 62 | 2.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн | 2.2.1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 80 | Улсын төсөв | Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн 2022 онд үйлдвэрийн барилгыг ашиглалтад оруулсан. БНХАУ-ын Шанхай хотоос үйлдвэрийн тоног төхөөрөмжийг захиалан авч угсралтын ажил дууссан. Цаашид тус үйлдвэрийн үйл ажиллагааг "Ингэн Эрдэнэ" ОНӨААТҮГазар хариуцан ажиллана. Мөн мах ногооны зоорь, бойны газар барих төслийг эхлүүлэн ашиглалтад оруулаад байна. Хөдөө аж ахуйн цогцолборын үйлдвэрлэлийн бүсийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд “Алтай эколос” ХХК, цахилгааны эх үүсвэрийн материал нийлүүлэх ажил, гадна холбооны шугамын материал нийлүүлэх ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. 2022 онд 850 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон. 2023 онд 823.7 сая төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс авсан байна. Хөдөө аж ахуйн кластерын нийт ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. | 100% |
| 63 | | 2.2.2. Хөдөө аж ахуйн кластер төслийн | | Гүйцэтгэлийн хувь | 70 | Улсын төсөв | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн кластер байгуулах ажлыг 12,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ба | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | газар тариалан, малын тэжээл дэд төслийг хэрэгжүүлэх | | | | | үүнд Ингэний сүүний үйлдвэр, ногоон тэжээлийн үйлдвэр буюу өвлийн хүлэмж, мах ногооны 1000 тн-ны зоорь, бойны газрын барилгын ажил, шинэ суурьшлын бүсийн цэвэрлэх байгууламж, цахилгаан эх үүсвэр, гадна холбооны шугам зэрэг ажлууд хийгдэнэ. Дээрх ажил 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 7 тэрбум төгрөгийн ажил хийгдэн санхүүжилтээ аваад байна. Хөдөө аж ахуйн кластерын Газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн ажил бөгөөд нийт 10,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй. Тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан "Баян-Өсөх-Агро" ОНӨҮГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу энэ онд 1. Хөдөө аж ахуйн кластерын барилга байгууламжийн ажил (Багц-1)-500 тн-ын багтаамж бүхий зоорь агуулах баригдсан. 2. Гүн өрмийн худаг, Ногоон тэжээлийн талбайг хашаажуулах (Багц-2)-Гүн өрмийн худгийг Бууцагаан, Өлзийт, Хүрээмарал сумдад гаргасан. Малын тэжээл тариалах зорилгоор Баацагаан, Бууцагаан, Хүрээмарал, Баянлиг сумдад тус бүр 50 га талбайг хашаажуулаад байна, 3. Хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж (Багц-4)-Газар тариаланд ашиглах улсын төсвийн 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 25 морины хүчин чадалтай 6 трактор, 90 морины хүчин чадалтай 6 трактор, тэжээлийн ургамал тариалах, хураах иж бүрэн агрегат дүүжин машинуудын хамт, 6 ширхэг хүлэмжийн мото-блок тус тус шинээр авч ашиглаж байна. Тайлант онд 4,2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. | |
| 64 | | 2.2.3. Ингэний сүүний үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Улсын төсөв | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 6 багц ажил, арга хэмжээний тендер зарлагдан хэрэгжиж байгаа бөгөөд үүний нэг болох Ингэний сүүний үйлдвэрийг байгуулах ажил нь үйлдвэрийн барилгын ажлыг барьж хүлээлгэн өгсөн. Аймгийн ИТХ-ын 2021 оны 3/7 тоот тогтоолоор "Ингэн эрдэнэ" ОНӨААТҮГ байгуулж ингэний сүүний үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах, гадаад дотоод зах зээл, | 98% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | фермер байгуулах зэрэг ажлыг БНХАУ, Өмнөговь аймгуудаас туршлага судлан ажиллаж байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-н Шанхай хотоос захиалж, урсгал шугамыг угсрах ажил хийгдэж байна. Уур үйлдвэрлэлийн хэсэг бүрэн угсрагдсан, сүү бэлтгэх өтгөрүүлэх хэсгийн угсралт 80%, хатаах хэсгийн угсралт 20%, сав баглаа боодлын хэсэг 20% угсралттай ажил үргэлжилж байна. Цаашид ОХУ-аас авах сеператор зэрэг цөөн тооны тоног төхөөрөмж ирвэл үйлдвэрийн шугам иж бүрэн болж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэнэ.Ажлын гүйцэтгэл 98 хувьтай байна. | |
| 65 | | 2.2.4. Хангайн бүсийн тогооч нарын ажил мэргэжлийн уралдаан, урлаг спортын наадам зохион байгуулах | | Оролцогчдын тоо | 100 | Хөжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10 сая төгрөг | Баянхонгор аймгийн Засаг даргын нэрэмжит “Өнгүүр буурч цом-2023 ”Баруун бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, спортын нөхөрсөг тэмцээнийг 2023 оны 05 сард Баянхонгор аймагт зохион байгуулсан. Тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Монголын тогооч нарын холбоо, Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо ажиллаж, Аймгийн ХХААГ, БШУГ, БОАЖГ, БТСГ, СХЗГ, ЭМГ, Политехник коллеж, МҮХАҮТ-ын салбар, Эрчим хүч ТӨҮГ, зэрэг хэлтэс агентлаг, байгууллагууд хамтран ажиллалаа. Баруун бүсийн аймгууд болох Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Ховд, Увс, Баянхонгор аймгуудын Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажилладаг 150 орчим тогооч, дагалдах албаны хүмүүс, дасгалжуулагчдын хамтаар ирж 11 төрөлд өрсөлдөн шилдгүүдээ шалгаруулан урамшуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн Засаг дарга, Монголын тогооч нарын холбоотой хамтран зохион байгуулсан “Улсын залуу аварга тогооч-2023” уралдаанд 2023 оны 01 дүгээр сарын 21-26-ны өдрүүдэд орон нутгийн залуу тогоочдыг хамруулан оролцлоо. Монгол Улсын залуу аварга тогооч шалгаруулах ур чадвар, ажил мэргэжлийн 12 дахь уралдаанд 17 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 215 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | залуу тогооч 4 төрөлд өрсөлдсөн бөгөөд Баянхонгор аймгаас “Орчин үеийн Монгол хоол”-ны төрөлд 18-29 насны ангилалд О.Сүмбэрэлзул Тэргүүн байр, “Орон нутгийн онцлог бүхий үндэсний хэв маяг уламжлал агуулсан брэнд хоол бүтээх төрөл”-д Баянхонгор Политехникийн коллежийн оюутан Б.Жавхлантөгс Тэргүүн байр, “Ганцаарчилсан гранпри” төрөлд тогооч Б.Балчин Гутгаар байр, “Багийн гранпри” төрөлд багаараа Тусгай байр буюу 4 төрөлд тус бүрт амжилттай оролцож байр эзэллээ. | |
| 66 | | 2.2.5. Хүн амын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэх | | Нөөцөлсөн махны хэмжээ /тонн/ | 180 | | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 180тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгж нь Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийж байна. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2023 оны 04 дүгээр сарын 04-өөс 06 дугаар сарын сарын 04 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 80.0 сая төгрөгийг “Баянхонгор констракшн" ХХК-д олгосон. | 100% |
| 67 | | 2.2.6. Баянхонгор аймагт импортоор оруулж ирж байгаа,орон нутагт үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэж экспортонд гаргаж болох бараа бүтээгдэхүүний судалгааг гаргах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн аймгийн | | Судалгааны тоо | 3 | | Аймгийн ИТХ-аас “ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН АЙМГИЙН ЗӨВЛӨГӨӨН”-ийг бүх сумуудад зохион байгуулах шийдвэр гаргаж, “Хөгжилд залуучуудын оролцоо түншлэл” ТББ, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагуудтай хамтран бүх сумдад зөвлөгөөн зохион байгуулж, сум орон нутгийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийг хамруулж тэдний өмнө тулгамдсан асуудлуудад нь зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажилласан. | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөгөөн зохион байгуулах | | | | | | |
| 68 | | 2.2.7. Аймаг, орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор “НЭГ ӨРХ, НЭГ БАЙГУУЛЛАГА, НЭГ СУМ-НЭГ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ” шалгаруулах болзолт уралдаан зарлаж, шалгарсан бүтээгдэхүүнүүдийг бодлогоор дэмжих | | Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо | 9 | | Аймгийн ИТХ-ын даргын баталсан “Намрын ногоон өдрүүд Баянхонгор брэнд” үзэсгэлэн худалдаа, болзолт уралдаан шалгаруулах нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу болзолт уралдааныг 20 сум, иргэн ААН-дэд зарлаж шилдгүүдийг АИТХ-ын даргын 2023 оны 80-р захирамжаар баталсан ажлын хэсэг тодруулж, 6 төрөлд 17 иргэн, ААН-ийг 40.0 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнасан. Мөн энэ үеэр Шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж хонь, ямаа, үхэр зэрэг шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчийг шалгаруулсан нь “Буянт сүргийн эзэн” 1000 малчдын зөвлөгөөнд 20 сумаас ирсэн малчдад танилцаж, туршлага судлах, мал сүргээ шилдэг ашиг шим сайтай үүлдэр омгийн малаар сайжруулах боломжтой ойлгуулсан томоохон арга хэмжээ болсон. | 70% |
| 69 | 2.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс | 2.3.1. Сарлаг үхэр , баталгаажсан үйлдэр омгийн хээлтэгч малд шилэн сонголт хийх | | Шилэн сонголтод хамрагдсан малын тоо /мянга/ | 11 | Малчдын хандив тусламж 9,8 сая төгрөг Улсын төсвийн 8,5 сая төгрөг Орон нутгийн хөгжлийн сан 18,0 сая төгрөг | Аймгийн хэмжээнд 2031 сарлаг үхэрт үзлэг ангилалт хийснээс 1287 үхрийг шинээр ээмэглэсэн. Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд 187 үхэр бүртгэгдсэн байна. Баянхонгор, Баянговь, Баян-Овоо, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Эрдэнэцогт зэрэг 10 сумын 5667 бог малд хээлтүүлэгчийн үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулсан. Мөн Баянбулаг, Баян-Өндөр, Богд, Жинст, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст зэрэг 7 сумын 5521 бог малын хээлтүүлэгчийн үзлэг ангилалтын ажлыг тухайн сумын хүний нөөцийн тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн. Гурванбулаг, Галуут, Өлзийт, Эрдэнэцогт сумын 1780 сарлагт, Баянлиг сумын 859 тэмээнд, Баянбулаг, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст сумын 4937 хонинд, Баянбулаг, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст, Баян-Өндөр сумын 2686 ямаанд нийт 10262 толгой малыг үзлэг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ангилалтанд хамруулсан. Бусад сумдууд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 306 малд үзлэг ангилалт хийсэн. Энэ онд нийт 31.7 мянган малд үзлэг ангилалт хийж, өмнөх оныхоос 6.8 мянга буюу 27.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цөм сүргийн малын тоо өнгөрсөн үеэс 3%-иар өссөн. Нийт сүргийн 8,4%-ийг эзэлж байна. | |
| 70 | | 2.3.2. Бод малд зохиомол хээлтүүлгийн туршилт, судалгаа хийх | | Зохиомол хээлтүүлэг хийсэн малын тоо | 100 | Орон нутгийн төсөв | Энэ онд 100 толгой хээлтэгчид зохиомол хээлтүүлэг хийхээр ажлын төлөвлөгөөг гарган бэлтгэл ажлыг хангасан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 4 сумын 11 малчны 82 үхэрт зохиомол хээлтүүлгийг амжилттай хийсэн. Хээлтүүлэг амжилттай болсон эсэхийг Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс мэргэжилтэн урьж 4D эхо аппаратаар шалгахад 70 хувьтай. Орон нутагт эхо аппарат дутагдалтайн улмаас нягтлан шалгах боломж хомс байна. Хээлтүүлгийн хувь нэмэгдэх боломжтой бөгөөд үр дүн 2024 онд мал төллөх үед гарна. | 82% |
| 71 | | 2.3.3. Шаардлагатай сумдын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах | | Шинээр гаргах худгийн тоо, засварласан худгийн тоо | 7 1 | Орон нутгийн хөгжлийн сан | Улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Баян-Овоо, Баян-Өндөр, Богд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баацагаан, Богд, Гурванбулаг, Өлзийт сумын нутагт гүн өмрийн худаг шинээр гаргах буюу сэргээн засварласан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баацагаан, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Галуут, Жинст, Өлзийт, Хүрээмарал сумдууд гүн өрмийн худаг гаргасан бол малчдын санаачилгаар Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Гурванбулаг, Хүрээмарал сумдууд энгийн уурхайн худаг тус тус гаргасан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Богд сум 5 цэгт, Шинэжинст сум 2 цэгт нийт 7 цэгт ус цэгийн хайгуул хийгдсэн байна. Нийт 16 худаг ашиглалтад орж 24,0 мянган га бэлчээр усжуулагдаж, 32,0 мянган мал усаар хангагдлаа. | 100% |
| 72 | | 2.3.4. Үлийн цагаан оготны судалгаа хийж, устгалын ажил зохион байгуулах | | Устгал хийгдсэн талбайн хэмжээ | 8 | Улсын төсвийн 188.0 сая төгрөг Аймаг, сумын орон нутгийн | Тайлант онд 18 сумын 43.3 мян га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | /мян.га/ | | төсвийн 93 сая төгрөг | ажлын гүйцэтгэл 92.3 хувийн үр дүнтэйгээр Улсын байцаагчийн дүгнэлт гарсан. | |
| 73 | | 2.3.5. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүлэмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | | Хүлэмжийн тоо | 25 | Улсын төсөв, иргэн аж ахуй нэгжийн хөрөнгө | Хүлэмжийн нэгдсэн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж "Нарлаг хүлэмж" ХХК-тай хамтран ажилласны үр дүнд 2 аж ахуйн нэгж, 13 иргэн нийт 18.0 сая төгрөгийн 15 хүлэмжийг өөрсдийн хөрөнгөөр худалдан авч ашиглаж эхлээд байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмж, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлэн 100 хүлэмжийн агропаркийг байгуулах ажил амжилттай хэрэгжсэн. Нийт 6060 м,кв талбайд 50 иргэн тариалалт хийж 2.7 тн ургац хураан авсан үр дүнтэй байна. Улсын төсвийн санхүүжилтээр 4000 мкв талбай бүхий 7, ЖДҮ-ийн сангаас 560 м.кв талбай бүхий 4, Хятадын хамтын ажиллагааны хүрээнд 1000 м/кв 2, иргэн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр 525 м/кв 3 нийт 6000 м/кв талбай бүхий 16 ширхэг 3 улирлын нарлаг хүлэмж барьж байгуулах ажил хийгдэж байна. Үүнээс энэ онд 2525 м/кв талбай бүхий 5 хүлэмж нь ашиглалтад орж тариалалтын туршилтаа эхлүүлэх боломжтой болсон байна. | 100% |
| 74 | | 2.3.6. Хүнсний хувьсгалын хөдөлгөөний хүрээнд иргэдийг сургалтад хамруулж, хүлэмжтэй болгох | | Сургалтад хамрагдаж хүлэмжтэй болсон өрхийн тоо | 200 | Орон нутгийн төсөв | Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний аюулгүй байдлыг хангах хөдөлгөөн”-ий хүрээнд Баянхонгор хот, БНХАУ-ын Жучуань хоттой 2023 оны 03 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу БНХАУ-ын Жучуань хотын Хөдөө аж ахуйн технологийг сурталчлах үйлчилгээний төв, Ойн жимсний үйлчилгээний төвд органик бордоо боловсруулах технологи, ойн мод үржүүлгийн технологи, нарны хүлэмжийн технологи чиглэлээр 6 техникчийг бэлтгэн Баянхонгор сумд Өлзийт Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, MOPG-IF Япон улсын ивээн тэтгэгч төрийн бус байгууллагатай хамтран сумын 10 багийн Засаг дарга, 85 тариаланч иргэдийг оролцуулсан сургалтыг зохион байгуулсан. “Green house” хүлэмжийн аж ахуйд тариалалт хийсэн 50 | 68% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэнд тариалалт хийх сургалтыг 2023 оны 05 дугаар 23-ны өдөр зохион байгуулсан. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмж, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлэн 100 хүлэмжийн агропаркийг байгуулах ажил амжилттай хэрэгжсэн. | |
| ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 75 | 3.1. Эх байгаль-Ногоон байгууламж | 3.1.1. Аймгийн хэмжээнд амьтны нэгдсэн суурь судалгаа хийж, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах | | Судалгаанд хамрагдсан сумын тоо | 20 | | Аймгийн хэмжээнд ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Агнуур судлалын нийгэмлэг” НҮТББ шалгарч, 20 суманд уулын туруутан амьтны судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, аймгийн ерөнхий агнуурын судалгаа, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Ан агнуурын менежментийн төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаан болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэн баталсан. | 100% |
| 76 | | 3.1.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх | | Тарьсан модны тоо | 500000 | Аж ахуйн нэгж, хувийн хөрөнгө, Улсын болон орон нутгийн төсөв - 892.3 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/252, А/537 дугаар захирамжийн дагуу 1259 айл өрх 17 төрлийн 14392 ширхэг мод, 130 аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа 8319 ширхэг мод, 333 ААН байгууллагын 10681 иргэн орчин тойрон болон бичил цэцэрлэг, саад, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн 30,7 га талбайд 47710 ширхэг мод, 15 сумын нутаг дэвсгэрт 48,6 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж 40616 ширхэг мод, 6 сумын нутаг дэвсгэрт 18,7 га талбайд зориудаар ойжуулалтын ажил хийж 6395 ширхэг мод, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 2 сумын нутаг дэвсгэрт 7 га талбайд хийж 1000 ширхэг мод нийт 20 сумын нутаг дэвсгэрт 105 га талбайд 118,432 ширхэг суулгац, Мод үржүүлгийн газрууд 187,623 ширхэг тарьц суулгацыг мөчир болон үрээр тарьж ургуулж байна. Аймгийн хэмжээнд 2023 онд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суулгацаар 118,432 ширхэг, үрээр болон мөчрөөр 187,623 ширхэг нийт 306,055 ширхэг модыг тарьж, бойжуулсан нь өмнө оноос 69 хувиар өссөн эерэг үзүүлэлтэй байна. | |
| 77 | | 3.1.3. Биотехникийн арга хэмжээ авах /амьтдын байршил бүхий газруудад хужир, мараа, өвс, тэжээл, хорголжин байршуулах/ | | Давтамжийн тоо | 4 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 57.4 сая төгрөг | Аймгийн хэмжээнд 2023 оны 01-05 дугаар сарын хооронд зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг хэсэгчлэн зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Баянбулаг, Жаргалант, Галуут, Бууцагаан, Гурванбулаг, Заг, Жинст, Хүрээмарал, Богд, Шинэжинст, Баян-Овоо, Бөмбөгөр зэрэг нийт 15 сумын нутаг дэвсгэрийг хамруулан зэрлэг амьтдын байршил бүхий газруудад идэш тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлж 36 удаагийн давтамжтай өвс 1423 боодол, хужир 19 тонн, хорголжин 47 шуудай байршуулж биотехникийн арга хэмжээ авсан. Биотехникийн арга хэмжээ авах үед Янгир ямаа-393, Аргаль угалз-96, Буга, согоо-56 тоо толгойг нүдээр үзэж тоолсон. | 100% |
| 78 | | 3.1.4. Усны тоо бүртгэлийг зохион байгуулах | | Тоо бүртгэлд хамрагдах сумын тоо | 20 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 20,0 сая төгрөг | Усны тухай хуулийн 17.1.14 дэх заалт Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1 дэх заалт Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний 3.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023оны 07дугаар сарын 07-ны өдрийн А/374 дүгээр тоот захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд Усны нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, сумдын Байгаль орчны албатай хамтран зохион байгуулсан. Аймгийн хэмжээний 20 сумын Гадаргын усны тоо бүртгэлийг хийж хээрийн ажил дуусаж суурин боловсруулалтын ажил хийгдэж байна урьдчилсан байдлаар сав газрын хэмжээнд гол-188, булаг шанд-1026, нуур тойром-125 тоологдсон шинээр гарсан гүн өрмийн болон энгийн уурхай худгийн тоо нэгтгэгдээгүй байна. | 90% |
| 79 | | 3.1.5. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл | | Хамгаалалтын бүсийн зураглал хийж, кадастрын | 20 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 10 сая | Аймгийн Засаг даргын 2023 оны А/72 дугаар захирамжаар аймгийн нутаг дэвсгэрийн усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн ба хязгаарлалтын бүсийг тогтоож, зурагжуулах ажлын хэсэг байгуулагдсан. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ахуйн бүсийн хамгаалалтын зураглал хийж баталгаажуулах | | санд бүртгэсэн сумын тоо | | төгрөг | Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2023 оны 61 дүгээр албан бичгээр усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн шэйп файлыг хүргүүлэн зөвлөмж авсан. Аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын 26, хайгуулын 21 тусгай зөвшөөрөл бүхий талбай усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд давхцалтай, удирдамжийн дагуу хангай, говийн 2 чиглэлд 2023 оны 05,06 дугаар сарууддад хээрийн ажил хийгдсэн. Тусгай зөвшөөрөлтэй 47 лицензтэй талбай байгаагаас ашиглалтын 22, хайгуул 10 нийт 32 талбайг газар дээр нь очиж тогтоосон ба тодотгол хийж зурагласан. Усны тоо бүртгэлд тоологдоогүй 108 булаг шанд, 18 гол, горхи, 6 нуурын мэдээллийг тодруулан, зурагжуулж усны мэдээллийн санд оруулаад байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, Усны газрын мэргэжилтэн, АМГТГ-ын ахлах мэргэжилтэн, Сумдын Засаг дарга нар оролцон 2023 оны 10 дугаар сарын 26-нд Улаанбаатар хотод хэлэлцүүлэг зохион байгуулсан. Холбогдох дээд шатны байгууллагад хянуулж дүгнэлт авах шатандаа явагдаж байна. | |
| 80 | | 3.1.6. Усны нөөцийн хомстол бохирдлоос хамгаалах, усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах | | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 4000 | Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал | Аймгийн засаг даргын 2023 оны А/135 дугаар захирамжийн дагуу "Дэлхийн усны өдөр"-ийг “Өөрчлөлтийг хурдасгая уриан дор тэмдэглэх аяны хүрээнд 6 төрийн байгууллага, 1 төрийн бус байгууллага хамтран төлөвлөгөөт хугацаанд 15 арга хэмжээг зохион байгуулсан. Нийт нөлөөллийн олон талт арга хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагч 230, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагч - 1270, Төрийн албан хаагч, ажилчид - 412 хамрагдаж, худаг болон цэцэрлэгийн эцэг эхчүүдэд 108 ширхэг гарын авлага тарааж, цахимаар давхардсан тоогоор 5436 хүнд мэдээлэл өгсөн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд цэцэрлэгийн сурагчдын ус уух боломжийг бүрдүүлэх, дадал хэвшил төлөвшүүлэх болзол уралдааныг зарласан тус уралдаанд оролцсон 16 цэцэрлэгийн 1270 гаруй сурагчид цэцэрлэгийн орчинд ус уух нөхцөл нь | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрдсэн. | |
| 81 | | 3.1.7. Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөл, Орог нуур Түйн голын сав газрын талуудын оролцооны зөвлөлийн хурлыг зохион байгуулж, үйл ажиллагааг дэмжих | | Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 | Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал 10,0 сая төгрөг | Бөөнцагаан нуур-Байдраг гол, Орог нуур-Түйн голын талуудын оролцооны зөвлөлүүд нь 2023 оны 07, 11 саруудад тус тус 2 удаагийн хурлыг зохион байгуулсан. Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай. Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр хурлын тэмдэглэл, төлөвлөгөөний биелэлтийн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Бусад сав газрын талуудын оролцооны зөвлөлийн гишүүдтэй цахимаар санал солилцсон. | 100% |
| 82 | | 3.1.8. Түйн гол түүний цутгал голууд болон Орог нууранд биологийн төрөл зүйлийн судалгаа хийх | | Судалгаа хийгдсэн төрөл зүйлийн тоо /Баг, овог, зүйл/ | 18, 28, 73 | | Түйн гол түүний цутгал голууд болон Орог нуурын биологийн төрөл зүйлийн судалгаа хийх ажлыг “Усны эргүүлэг” ХХК-тай гэрээ байгуулсан. Судалгааны баг хээрийн дата мэдээлэл цуглуулах ажлаа Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай хамтран хийж гүйцэтгэн, гэрээний дагуу биологийн төрөл зүйлийн судалгааны тайланг хүлээлгэн өгсөн. Судалгаагаар Шавжтайн баг 5 зүйл, далавчтаны баг 8, туулайны баг 5, мэргэчийн баг 30, мах идэштний баг 16, туруутны баг 7 зүйл нийт 71 зүйлийн хөхтөн, шувуудын 72 зүйл байна. | 100% |
| 83 | | 3.1.9. Баянхонгор сумын хүн амын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх / судалгаа / | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Байгууллагын төсөв 3.0 сая төгрөг | Баянхонгор аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуулын судалгаа хийгдсэн. Судалгаагаар одоогийн ашиглагдаж буй хүн амын ундны усны эх үүсвэр нь өөрийн урсгалаараа айл өрх, аж ахуйн нэгжүүдэд хүргэгдэж байгаа ба хүн амын унд ахуйн усны хэрэглээ өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор усны эх үүсвэрийн өргөх ноцоосыг байршуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Судалгааны ажлын гүйцэтгэл 80 хувьтай, тус худаг нь ашиглагдаагүй нөөцөд байна. Цаашид ашиглалтын хайгуул хийлгэх шаардлагатай, ус хангамжийн эх үүсвэрийн 2 дахь худгийг лайдаж, ундаргыг сэргээхээр “Онги-Ус “ ОНӨГ-тай хамтран ажилласан. | 80% |
| 84 | | 3.1.10. Байдраг, Түйн голын сав дагуу хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор суурин газрын бохир | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Байгууллагын төсөв 30,0 сая төгрөг, Баянхонгор сумын 30,0 сая | Байдраг, Түйн голын сав дагуу хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор "Чандмань Баянхонгор" ХК 10 тн хүчин чадалтай бохир ус соруулах тусгай зориулалтын авто машин болон цэвэр усаар хангах автомашинтай болсон. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | соруулах болон цэвэр усаар хангах тоног төхөөрөмжтэй болох | | | | төгрөг, Орон нутгийн төсвөөс 100,0 сая төгрөг нийт төсөв 160,0 сая төгрөг | | |
| 85 | | 3.1.11. Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | Хур тунадасны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад /мм/ | 0.6 | | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааны журам болон экспедицийн бие бүрэлдэхүүн цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа хариуцсан газрын мэргэжилтнүүдтэй тогтмол харилцаж, заавар зөвлөмж авч үйл ажиллагааг явуулсан. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг эрчимжүүлснээр энэ оны 7 дугаар сард өмнөх жилээс зуншлагын байдал 30 хувиар сайжирч, гандуу үнэлгээ 10 хувиар буурсан байна. Мөн 9 дүгээр сард өмнөх жилээс зуншлагын байдал 15 хувиар сайжирч, гандуу үнэлгээ 25 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Бэлчээрийн даац багтаамж өмнөх жилийн зуншлагын байдлын 10 хоног тутамд үнэлсэн зургаас үзвэл 6 дугаар сарын 20-ноос 8 дугаар сарын 20-ны хугацаанд нийт нутгийн 5 орчим хувьд сайн, 50 гаруй хувьд дунд зэрэг, 45 орчим хувьд муу гэж үнэлэгдсэн байсан бол энэ оны зуншлага 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 20 хувьд зуншлага сайн, 70 хувьд дунд зэрэг, 10 орчим хувьд муу гэж өмнөх оноос зуншлага 15 хувиар сайжирч, гандуу байдал 20 хувиар буурч зуншлага сайжирсан байна. Мөн 5 дугаар сард Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Хүрээмарал, Шинэжинст, Баянбулаг, Баян-Өндөр, Гурванбулаг сумын нутгаар олон жилийн дунджаас 4.1-25.3 миллиметрээр их хур тунадас орсон. Энэ гаралтад 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 80-90 хувьд хамруулж хур тунадас нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийн тооцвол аймгийн нутгаар нэмэгдүүлсэн хур тунадасны үнэ 161710000 төгрөгт хүрсэн. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үеийн орчны бичлэг, зураг баримтуудыг цахим архив үүсгэнэ FTP-д /1_Tsag_uur_orchnii_shinjilgeenii_gazar/1. Ulsiin suljee, uur amisgaliin uilchilgeenii heltes/Tsag agaart zoriudaar nolooloh/bayankhongor/bkhr zurag bichleg | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байрлуулсан | |
| 86 | | 3.1.12. Эвент арга хэмжээ зохион байгуулж, оролцох | | Гадаад, дотоод жуулчдын тоо | 200<br>17000 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжлүүлэх арга хэмжээний зардал 87,0 сая төгрөг | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Баяхонгор аймагт 2023 онд дараах томоохон ажлын хийж хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Тэмээ тэнгэрийн амьтан" тэмээний баяр, "Түйн голын жавар-2023" өвлийн наадмыг тус тус зохион байгуулж нийт 5000 гаруй дотоодын аялагч оролцсон. Аймгийн хэмжээнд нийт 3 томоохон эвент зохион байгуулж 12,000 мянган жуулчид оролцсон. Монгол улсын хэмжээнд Олон улсын аялал жуулчлалын арга хэмжээ болох "Монгол туургатны харвуул их наадам"-ыг Заг-Байдрагийн хүрэн бэлчирт 07 дугаар сарын 19- 21-ний хооронд амжилттай зохин байгуулж, ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, 21 аймгаас оролцохоор ирсэн харваачид, тухайн орон нутгийн малчид, төлөөлөгчид, , ЖДҮ эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэг нийт давхардсан тоогоор 7000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид 120.0 гаруй сая төгрөгийг орлого олсон. Мөн тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр адал явдалт унадаг дугуйн аялал, Морин аялал, хадны сүг зураг сонирхох аяллуудыг зохион байгуулж салбарын контент аяллын шинэ, хөтөлбөр маршрутыг гаргаж гадаад зах зээл дээр гаргахад бэлэн болсон. Зочлох үйлчилгээний салбарын тогооч нарын "Өнгүүр буурч 2023" ур чадварын тэмцээнийг Баянхонгор хотод 2023 оны 05 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд, Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний салбарын удирдлага, менежер, үйлчилгээний ажилчдыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 06 сарын 05, 06-нд тус тус зохион байгууллаа. Жил бүрийн 10 сард зохион байгуулагддаг Монголын аялал жуулчлалын салбарын томоохон арга хэмжээ "Ай Ти Эм-2023" аялал жуулчлалын үзэсгэлэн Хонгор нутгаа төлөөлж аймгийн зочид буудал, жуулчны баазуудыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж оролцсон. | 70% |
| 87 | | 3.1.13. Баянхонгор | | Эко ариун | 360 | Орон нутгийн | Баянхонгор сумын гэр хорооллын инженерийн шугам | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сумын гэр хороололд "Эко" 00 нэмэгдүүлэх | | цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо | | хөгжлийн сангийн 100,0 сая төгрөг | сүлжээний ажлыг 2022 онд эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд Дулааны шугам 4620м, ариутгах татуурга 17100м, цахилгаан 3800м, холбоо 2070м, халаалтын зуух 2ш 15м*30м хэмжээтэй, ус дулаан дамжуулах төвийн барилга 12м*9м хэмжээтэй, бохир усны насос станцын барилга, дэд өртөөний барилга тус тус хийгдэхээр төлөвлөгдсөн. Тайлант онд Гэгээн шавь 6-р багт 476м дулааны шугам, 5,6-р багийн халаалтын тогооны 15х30м хэмжээтэй ус, дулаан дамжуулах төвийн барилгын суурийн цутгалтын ажил, Дуурсах 3-р багт 604 м дулааны шугамын угсралтын ажил, 1320 м бохирын шугам, 2,7,9 дүгээр багт 2100 м урт цэвэр усны шугам, 3500 м урт бохирын шугамын угсралтын ажил, 4,5-р багт ф200-ийн 420м урттай ширмэн хоолойн угсралт, цэврийн ф75, ф50-ийн HDPE хоолой 1736м, бохирын ф160-ийн давхар эрчлээстэй 1792 м урт хоолойн угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрх ажил бүрэн хэрэгжиж дууссанаар Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхийн 30 хувь нь инженерийн шугам сүлжээнд холбогдож, нүхэн жорлонгүй болно.Баянхонгор сумын 9 багийн 180 өрхөд 3-н кольцо нийлүүлэх ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд 180 өрх стандартын шаардлагад нийцсэн эко ариун цэврийн байгууламжтай болсон. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ний 02 дугаар албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд эко ариун цэврийн байгууламжтай жуулчны бааз-2ш, төрийн байгууллага-35ш, аж ахуй нэгж, байгууллага-188ш, сургууль цэцэрлэг-23ш, айл өрх- 692 ширхэг байна. Шаардлага хангахгүй 122 ширхэг нүхэн жорлонг буулгасан. Нүхэн жорлонгийн судалгааг жил болгон хийж хэвшсэн. Сар бүр орчны бохирдол, стандартын бус нүхэн жорлон, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, усны сан бүхий газрыг бохирдож, хомстохоос хамгаалах, хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг сар бүр зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. | |
| 88 | | 3.1.14. Аймгийн | | Нөхөн | 6 | Орон нутгийн | Аймгийн төвийн 2009-2023 он хүртэл 14 жил | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 91 | | хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх | | сэргээсэн талбайн хэмжээ /га/ | | төсөв | ашигласан хогийн цэгийн 6 га талбайг түрж булшлан техникийн нөхөн сэргээлт хийж, баруун хойд талын 1 га талбайг хашиж хамгаалан улиас, хайлаас, шар хуайс, буйлс зэрэг 4 төрлийн 6 эгнээ 1000 ширхэг модыг тарьсан. | |
| ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 89 | 4.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал | 4.1.1. Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх | | Замын урт /метр/ | 900 | Замын сангийн хөрөнгө | Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун талын уулзвар хүртэлх 900м хатуу хучилттай авто замыг шинэчлэн барих ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. | 100% |
| 90 | | 4.1.2. Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх | | Нөхөөсний хэмжээ /м2/ | 1500 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлыг Баянхонгор сум руу эрх шилжүүлж, тендэр сонгон шалгаруулалтыг зарлан "Их богд зам" ХХК шалгарч Замын сангийн 80,0 сая төгрөгөөр 1500м2 эвдэрсэн зам талбайд нөхөөсний ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 91 | | 4.1.3. Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам хийх | | Замын урт /метр/ | 2200 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын тендэр сонгон шалгаруулалтыг зарлаж үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Тэнгэрийн уул” ХХК-тай 2023 оны 2023/24 дугаартай 219,918,942.0 төгрөгийн гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2664м2 явган зам, 155м2 бетон гарцыг хийж гүйцэтгэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны А/447 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. | 100% |
| 92 | | 4.1.4. Соого сейко сургуулийн арын уулзвараас арван мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх | | Замын урт /метр/ | 1600 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын тендэр сонгон шалгаруулалтыг зарлан “Буян арвижих од” ХХК шалгарч 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 2023/61 дугаартай 222,000,000.0 төгрөгийн гэрээ байгуулсан. Ажлын хүрээнд 2100м2 явган зам, 2350м урт босоо бордюр хийж гүйцэтгэж, аймгийн Засаг даргын 2023 оны А/447 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. | 100% |
| 93 | | 4.1.5. Онцгой байдлын газрын уулзвараас баруун | | Замын урт /метр/ | 2200 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын тендэр сонгон шалгаруулалтыг зарлаж 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Унага трейд” ХХК-тай | 84% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу дугуйн зам хийх | | | | | 2023 оны 03-дугаар сарын 8-ны өдөр 210,183,430.0 төгрөгийн 2023/22 дугаартай гэрээ байгуулсан. Ажлын хүрээнд 1850м урт дугуйн замын ажлыг хийж гүйцэтгэн аймгийн Засаг даргын 2023 оны А/447 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ашиглалтад хүлээн авсан. | |
| 94 | | 4.1.6. Аймгийн төвд стандартын шаардлага хангасан хурд сааруулагч байршуулах | | Хурд сааруулагчын тоо | 10 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлыг "БМБЖБ" ХХК-тай шууд гэрээ байгуулж Баянхонгор сумын 10 байршилд хурд сааруулагч байршуулж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |
| 95 | | 4.1.7. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Шинэ суурьшлын бүсийн 10км хатуу хучилттай авто замын зураг төсвийг 2021 онд “Ихэр мөнх” ХХК хийж гүйцэтгэсэн. Тус ажлын тендэр сонгон шалгаруулалт зарлагдаж 2022 оны 03 дугаар сарын 22-ны үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Түм дэлгэрэх” ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 7,995,198,327.00 төгрөгийн 2022/53 дугаартай гэрээ байгуулсан. Авто замын далангийн ажил 10км газар бүрэн хийгдсэн. Автозамын бүх бордюрыг цутгаж дууссан ба 3.8км газарт бордюр суулгаад байна. Нийт авто замын барилга угсралтын ажлын явц 60%-тай явагдаж байна. | 40% |
| 96 | | 4.1.8. Эрдэнэцогт сумын Шар хөтөл, Ямаан усны даваан дээд ёроолын 2.4км шороон замыг засварлан сайжруулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Талын нөмөр“ ХХК шалгарсан. Тус 2.4км шороон замыг бүрэн засварлаж ашиглалтад хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай.<br><br>Хавсралт : 4 файл | 100% |
| 97 | | 4.1.9. Өлзийт сумын Гялгарын давааг засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Талын нөмөр“ ХХК шалгарсан. Тус 1.7км шороон замыг бүрэн засварлаж ашиглалтад хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 98 | | 4.1.10. Галуут сумын Сүмбэрийн багийн замыг засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Талын нөмөр“ ХХК шалгарсан. Тус 3.2км шороон замыг бүрэн засварлаж ашиглалтад хүлээн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авсан.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай | |
| 99 | | 4.1.11. Гурванбулаг сумын зам даваа засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн хөгжлийн сан 30,0 сая төгрөг | Тус ажлыг Гурванбулаг сум руу эрх шилжүүлсэн ба Гурванбулаг сумаас гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендэр зарлаж "Баясах гоо ихэр" ХХК шалгарч тус ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 100 | | 4.1.12. Баян-өндөр сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Сумын орон нутгийн хөгжлийн сан 20,0 сая төгрөг | Тус ажлыг Баян- Өндөр сум руу эрх шилжүүлж хийж гүйцэтгэсэн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай | 70% |
| 101 | | 4.1.13. Баянцагаан сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлыг Баянцагаан сум рүү эрх шилжүүлж хийж гүйцэтгэсэн.Орон нутгийн чанартай нийт 70 км замыг 5 хэсэг газарт жалга, судаг тэгшлүүлж, 6 хэсэг газарт замын ховил сэргээн засварласан.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 102 | | 4.1.14. Шинэжинст сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Тус ажлын зураг төсөв хийгдээгүй тул тайлант онд хэрэгжээгүй болно. | 0% |
| 103 | | 4.1.15. Баянлиг сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Тус ажлын зураг төсөв хийгдээгүй тул тайлант онд хэрэгжээгүй болно. | 0% |
| 104 | | 4.1.16. Баянговь сумын зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Тус ажлын зураг төсөв хийгдээгүй тул тайлант онд хэрэгжээгүй болно. | 0% |
| 105 | | 4.1.17. Шаргалжуут багийн зам засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замны сангийн хөрөнгө | Тус ажлын хүрээнд "Шаргалжуут буянт хайрхан" ХХК-тай шууд гэрээ байгуулж Баян давааны дээд, доод тохойн хэсэгт тэгшилгээ хийж нягтруулсан мөн Шаргалжуут тосгоноос рашаан сувилал явах хэсгийн эвдрэл гэмтэл үүссэн хэсгүүдийг хайргаар дүүргэж тэгшилгээ хийж нягтруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 106 | | 4.1.18. Заг сумын модон гүүрийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Хийморь орд констракшн“ ХХК шалгарсан. Тус засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 107 | | 4.1.19. Баянхонгор сумын 1,10-р багийн орон сууцнуудын дундах шороон замыг засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн хөгжлийн сан | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлаж “Тэнгэрийн уул“ ХХК шалгарсан. Тус ажлын хүрээнд 4436м2 эко хавтан, 700ш бордюр нийлүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 108 | | 4.1.20. Баянхонгор сумын шаардлагатай | | Явган замын урд /м2/ | 17900 | Замын сангийн хөрөнгө | Баянхонгор сумын шаардлагатай газруудад явган хүний зам байгуулах ажлыг гүйцэтгэхээр "Их буянт" | 38% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | газруудад явган хүний зам байгуулах | | | | | ХХК-тай 196,347,197.0 төгрөгийн шууд гэрээ байгуулж 2500м2 эко хавтан, 500м2 явган замын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | |
| 109 | | 4.1.21. Хөгжимт драмын театр явган хүний гарцыг стандартын дагуу тохижуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | "Мандай групп" ХХК-тай ажил гүйцэтгэх шууд гэрээ байгуулсан ба тус ажлыг бүрэн хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээж авсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 110 | | 4.1.22. 5-р сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын хүрээнд "Мандай групп" ХХК-тай шууд гэрээ байгуулж 5-р сургуулийн урд талын явган хүний гарцыг стандартын дагуу тэмдэг тэмдэглэгээ хийж суулгасан. Мөн тухайн сургууль нь Улсын чанартай авто зам дагуу байрладаг тул учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж сургууль орчмыг бүрэн харах чадалтай сайн чанарын гадна талбайн 360 камер суурилуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 111 | | 4.1.23. Номундалай цогцолбор сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын хүрээнд "Гурван мандал хайрхан" ХХК-тай шууд гэрээ байгуулж Номундалай цогцолбор сургуулийн баруун талын гэрлэн дохиотой явган хүний гарцыг 1.5м -ийн өргөнтэй байсныг хуучин цахилгааны шон, ногоон байгууламж зэргийн байршлыг шилжүүлэн 4.5м-ийн өргөнтэй болгож өргөсгөсөн. Мөн хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ явган замын ажлууд тус тус хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 112 | | 4.1.24. "Номгон" ахлах сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах | | Зам тээврийн осолд өртөх тоо | 95 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын хүрээнд “Танан хишиг” ХХК-тай шууд гэрээ байгуулж Баянхонгор сумын 1-р баг "Номгон" ахлах сургууль орчмын 600 м2 явганы зам, шороон зам, талбайг эко хавтангаар хучих ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Зорчих хэсгийн явган замыг стандартын дагуу тохижуулсан. | 100% |
| 113 | | 4.1.25. Эрдэм ахлах сургууль хүртэлх шороон замыг засварлах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Тус ажлыг Баянхонгор сумын ОНХСангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Баянхонгор аймгийн 2023 оны төсөвт тусгагдсан Замын сангийн 15.0 сая төгрөг зарцуулагдаагүй болно. | 100% |
| 114 | | 4.1.26. Зам | | Давсны | 40 | Замын сангийн | Тус ажлыг Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазарт | 84% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | арчилгаанд давс худалдан авах | | хэмжээ /тн/ | | хөрөнгө | эрх шилжүүлэн гүйцэтгүүлж 33.3тн давс худалдан авч нөөцөлсөн. 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 5 удаа цас ороход нийт 32,5 тонн давсаар халтиргаа гулгааг арилган иргэдэд аюулгүй, ээлтэй орчныг бий болгон ажилласан. | |
| 115 | | 4.1.27. Чандмань-Баянхонгор ХК-ний авто зогсоол | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Замын сангийн хөрөнгө | Тус ажлын хүрээнд 2000м2 талбайг тэгшилж цэцэрлэгт хүрээлэн болон Усан оргилуурын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт ажлын төсөвт өртөг 82.5 сая төгрөг, Замын сангаас 20.0 сая үлдэгдэл санхүүжилтийг Чандмань-Баянхонгор ХК дотоод нөөц бололцоогоо ашиглан хийж гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 116 | | 4.1.28. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийг хийх ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 45 | | Баянхонгор аймгийн 110/35/6 кВ-ын 12 МВА суурилагдсан чадалтай дэд станцын өргөлийн ажлыг 110/35/10 кВ-ын 36 МВА суурилагдсан чадалтайгаар өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ Трейд" ХХК-тай гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 5CVG 2ш бүрэн суурилуулсан. Энэ онд Хаалттай хуваарилах байгууламж, 10кВ-ын 16 МВА суурилагдсан чадалтай трансформаторыг бүрэн суурилуулж дуусаад байна. Тус ажил нь 2024 оны 08 дугаар сард ашиглалтад орно. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. | 100% |
| 117 | | 4.1.29. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 40 | Гадаадын зээл тусламж | Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хот суурин газрын дулаан хангамжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. ТЭЗҮ боловсруулалтын ажил хийгдэж дууссан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан Инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК гэрээ байгуулсан. 2022 онд барилгын суурийн ажил дууссан ба хөрс нягтруулалт, шороо булалтын ажил хийгдсэн. Энэ онд дулааны станцын барилгын ган каркасын 1 дүгээр үеийн угсралтын ажил, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Конивейер- 1, 2-ын суурь, Бутлуурын барилгын суурь, Нүүрс хүлээн авах барилгын төмөр бетон хийцийн ажил, Утаа сорогчийн барилгын суурь, Цахилгааны барилгын суурь, Харуулын байрны барилгын суурь, Зуух 1, 2, 3 халах гадаргуугын угсралтын ажлууд бүрэн хийгдэж дууссан ажляын гүйцэтгэл 80 хувьтай. Тус төсөл нь 2024 оны 09 дүгээр сард ашиглалтад орно. | |
| 118 | | 4.1.30. Үүрэн холбооны сүлжээ | | Үүрэн холбооны сүлжээ бий болгосон сумын тоо | 7 | Улсын төсөв | Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мянган өндөр цамхаг" ХХК Өлзийт, Эрдэнэцогт, Гурванбулаг, Баянлиг, Хүрээмарал, Баянцагаан нийт 6 сумын алслагдсан багуудад үүрэн холбооны сүлжээний цамхаг барьж 2023 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. | 100% |
| 119 | | 4.1.31. Баацагаан сумд "Сумын төвийн шинэчлэл" төсөл хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Улсын төсөв | Баацагаан сумын “СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ” төслийн сонгон шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Рино Инженеринг” ХХК шалгарч 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 4,995,000,000 төгрөгийн төсөвтэй 2022/56 дугаар гэрээг байгуулсан. Замын зургийн гүйцэтгэгчээр "АРВАЙ НУТГИЙН ЗАМ” ХХК, сумын төвийн шинэчлэл ажлын буюу цэвэр, бохир, дулааны зураг төслийг “ДУКАТ” ХХК, инженер геологийн судалгааг “ИНЖ ГЕО ТЕХ” ХХК гүйцэтгэсэн, барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл БАЭҮЗ-64-16/23. Баацагаан сумд: Бохирын 78ш худгийг угсарч бохир усны нийт 2170 м урт шугам, ДУХ 2.5мх3м 3ш худаг, 2.5мх2.5м 2 ширхэг худаг угсарч нийт 575 м урт шугамын угсралтын ажлыг хийж дуусгасан ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Тус ажил 2024 оны 04 дүгээр улиралд ашиглалтад орно. | 70% |
| 120 | | 4.1.32. Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Улсын төсөв | Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг хэрэгжүүлэх төслийн тендер сонгон шалгаруулалтыг 2022 онд зарлаж, 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр 2.290.685.909 төгрөгийн өртөг бүхий 2022/428 тоот гэрээг “Шинэ өлгийн зам " ХХК-тай байгуулсан. Барилга угсралтын туслан гүйцэтгэгчээр “ Эко эвсэг зам “ ХХК ажиллаж байна. 2023 онд авто замын ажил замын хөлдөлтийн гүнээс | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дээш 1-р үеийн газар шорооны ажил хийгдсэн. | |
| 121 | | 4.1.33. Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 35 | Улсын төсөв | Улсын төсвийн 25,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор сумын Гэр хорооллын шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж "Б софт" ХХК шалгаран гэрээ байгуулж 2022 оны 06 сараас шугам сүлжээний угсралтын ажлыг эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд Дулааны шугам 4620 м, Ариутгах татуурга 17100м, Цахилгаан 3800м, Холбоо 2070м, Халаалтын зуух-2ш 15м*30м хэмжээтэй, 1 давхар, УДДТөвийн барилга 12м*9м хэмжээтэй, 1 давхар / 2ш/, Бохир усны насос станцын барилга 3.6м*3.6м хэмжээтэй 1 давхар, Дэд өртөөний барилга ХТП2*400 кВа, 2*630 кВа, чадалтай, 6м*9м хэмжээтэй, 1 давхар /6 ширхэг/ ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн. Энэ онд Баянхонгор сумын 2, 3, 6, 7, 9 дүгээр багуудын гэр хороололд дулаан, цэвэр, бохир усны шугам ажлуудыг эхлүүлсэн. Мөн Баянхонгор сумын 2, 3, 6, 7, 9 дүгээр багуудын гэр хороололд дулаан, цэвэр, бохир усны шугам ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай. Тус төсөл арга хэмжээ нь 2024 оны 10 дугаар сард ашиглалтад орно. Эдгээр дэд бүтцийн ажлууд хийгдсэнээр иргэдийн ая тухай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ. | 100% |
| 122 | | 4.1.34. Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Улсын төсөв | Баянхонгор сумын "Шинэ суурьшлын бүс"-ийн инженерийн шугам сүлжээний ажил 6.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гал хонгор" ХХК гэрээ байгуулан 2022 оны 07 дугаар сард угсралтын ажлыг эхлүүлсэн. Энэ онд гадна дулааны шугам 1258 м урт, ариутгах татуургын шугам 1320 м урт хийгдсэн бөгөөд тайлант оны төлөвлөгөөт ажил 100% хийгдсэн. Тус ажил нь 2024 оны 06 дугаар сард ашиглалтад орно. | 90% |
| 123 | | 4.1.35. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах | | Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулсан сумын тоо | 20 | Орон нутгийн төсөв | 2019 онд Баянлиг, 2020 онд Баацагаан, Баянцагаан, Шинэжинст, Баян-Өндөр, 2021 онд Жинст 2022 онд Богд, Баянбулаг сум нийт 8 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан. Энэ онд Эрдэнэцогт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан бол Баянговь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг "Говь Эко" | 60% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ХХК, Заг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг "Ланресс" ХХК, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг "Голдэн мэп" ХХК тус тус боловсруулж байна. Ингэснээр нийт 2019-2023 оны хооронд нийт 12 сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байна. Сумдууд нутаг дэвсгэрийн төлөвлөгөөтэй болсноор дэд бүтэц, бүтээн байгуулалтыг оновчтой хийж иргэнд ээлттэй төлөвлөлт хийж боломжийг бүрдүүлсэн | |
| 124 | | 4.1.36. Жинст сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар хийх | | Засварын ажлын явц,хувиар | 100 | Улсын төсөв | Жинст сумын Засаг даргын Тамгын газрын засварын ажлыг "Эх бүрдэн" ХХК хийж гүйцэтгэн ажлын гүйцэтгэл 100 хувьтай.2023 оны 08 дугаар сард ашиглалтад оруулж ажилтан албан хаагчдын ая тухай ажиллах орчныг бүрдүүлж, иргэдийн үйлчилгээ авах боломж нөхцөлийг сайжруулсан. | 100% |
| 125 | | 4.1.37. Бууцагаан сумын шинэ сумын засварын ажил | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Бууцагаан сумын Шинэ сумын төвийн засварын ажлыг "Буян арвижих од" ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд сургууль, дотуур байр, цэцэрлэгийн цонх солих, цонх засварлах, дулаалах, халаалтын паарны секц солих ажлууд хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна. Тус ажлын энэ онд батлагдсан төсөвт өртгийн ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Эдгээр ажлууд хийгдсэнээр сургууль цэцэрлэгийн орчин нөхцөл сайжирсан. | 90% |
| 126 | | 4.1.38. Баянхонгор сумын Номгон 1-р багийн 514 дүгээр байрын их засварыг ашиглалтад оруулах | | Засварын ажлын хэрэгжилтийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багт байрлах 514 дүгээр байрны их засварын ажлыг "Алегротовер констракшн" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирсан. | 100% |
| 127 | | 4.1.39. Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж дахин төлөвлөх/1,2,7,9/ | | Дахин төлөвлөлтөд орсон байрын тоо | 8 | | Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг дахин төлөвлөлтөд орж 125 айлын орон сууц ашиглалтад оруулсан. Рашаант 10-р багийн 1-р байрны дахин төлөвлөлтийн ажлын гүйцэтгэж7 давхар 49 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан. Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны хуучин барилгыг 2022 онд буулгаж, дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлж 8 давхар 4 блок орон сууцны хотхоны зураг төслийг эхлүүлж 1 ээлжийн 2 блок 96 айлын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | орон сууцны барилгыг 2023 оны 8 сард ашиглалтад оруулсан. Тайлант онд нийт 4 байрыг бүрэн ашиглалт оруулж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулсан. | |
| 128 | | 4.1.40. 10 дугаар байрны иргэдэд дахин төлөвлөлтийн нөхөн төлбөр олгох | | Нөхөн төлбөр олгосон өрхийн тоо | 36 | Орон нутгийн хөгжлийн сан | Баянхонгор сумын 10 дугаар байрын иргэдэд нөхөн олговрыг 36 айл өрхөд 180,0 сая төгрөгийг олгосон байна. | 100% |
| 129 | | 4.1.41. Баригдаад олон жил болсон байрнуудын цэвэр бохирын шугамыг шинэчлэх /306,308,501,508,510, 512 / | | Шугам шинэчилсэн байрын тоо | 6 | Орон нутгийн хөгжлийн сан | Баригдаад олон жил болсон байрнуудын ариутгах татуургын шугамыг шинэчлэх ажлын гүйцэтгэгчээр "Содон сондор" цамхаг ХХК шалгаран, 150 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд 501, 510, 512-нийт 3 байрны ариутгах татуургын шугам сүлжээний засварын ажлыг гүйцэтгэн 2023 оны 05 сард улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан | 100% |
| 130 | | 4.1.42. Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | Баянбулаг сумын төвийн халуун усны барилгыг төвлөрсөн дулааны шугамд холбох ажлын гүйцэтгэгчээр "Би Би Ди Эм" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 131 | | 4.1.43. Баянбулаг сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтын ажил | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Баянбулаг сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг "Ган утас мөнх" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 132 | | 4.1.44. 2,6,9-р баг, Арван мянгатын ар, ойн зурвасаас хойш газар олгох газарт цахилгаан, гэрэлтүүлэг хийх, усан сан барих | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгийн хөгжлийн сан | Баянхонгор сумын Гэгээн шавь 6-р баг дугаар баг Өлзийт МСҮД ард 256 айлын газар олголт хийгдэж дууссан. Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүчинд холбох ажлын бараа материал нийлүүлэх ажлыг "Овоот сойвон" ХХК нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 133 | | 4.1.45. Жаргалант сумын орон сууцнуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Жаргалант сумын орон сууцуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг "Ерөөл нэмэх" ХХК хийж гүйцэтгэн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 134 | | 4.1.46. | | Гүйцэтгэлийн | 100 | | Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлагдаж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрдэнэмандал хайрханы өврийн төрийн байгууллагуудын авто зогсоол байгуулах | | хувь | | | “Унага трейд“ ХХК шалгарсан. Тус ажлын хүрээнд 6000ш эко хавтан, 3м-ийн урт 75ш төмөр хашаа, 370ш бордюр нийлүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | |
| 135 | | 4.1.47. Өлзийт сумын Бурхант багийн төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Өлзийт сумын Бурхант 1-р багийн төвийг засварлах ажлын гүйцэтгэгчээр "Гал гэрэл констракшн" ХХК гэрээ байгуулан засварын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 136 | | 4.1.48. Эрдэнэцогт сумын Ямаат, Өвгөнжаргалант багийн төвийн засвар | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Эрдэнэцогт сумын Ямаат 2-р дугаар багийн төвийн засварын ажлыг "Баянхонгор эко дулаан" ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Сумын ОНХС-аас 2022 онд 45 сая 2023 онд 47 сая төгрөг, аймгийн ОНХС-аас 108 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2023 оны 10 сарын 29-ний өдөр комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 137 | | 4.1.49. Жаргалан паркад хүүхдийн тоглоомын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх | | Гүйцэтгэлийн хувь | 100 | | Жаргалан паркад хүүхдийн тоглоомын цогцолбор байгуулах ажлыг "Бэнжцэс" ХХК-тай гэрээ байгуулсан. Энэ онд хөшөө, хашаа, хайс буулгах, газрын тэгшилгээ хийх зэрэг тохижилтын ажлыг эхлүүлсэн. 2023 оны төлөвлөгөөт ажил 100 хувь хийгдсэн. 2025 онд ашиглалтад оруулна. | 90% |
| ТАВ. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ | | | | | | | | |
| 138 | 5.1. Аюулгүй нийгэм, амар тайван орчин | 5.1.1. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | Орон нутгийн төсөв 5,0 сая төгрөг | Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/32 дугаар захирамжаар батлуулан, хэрэгжилтийг 100 хувьтай. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн хурлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулж, гарын авлагаар хангаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээний шашны байгууллагууд, малын эмийн сангууд, хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилган ажиллалаа. Үндэсний аюулгүй байдлыг мэдээ мэдээллээр хангах орон тооны бус зөвлөлийн гишүүдэд Үндэсний аюулгүй байдлын ажлын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албанаас сургалт зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт батлах тухай” 281 дүгээр тогтоолын хавсралтад аймгийн цэвэр усны байгууламжийг орон нутагт хамгаалалтад авахаар нэмж тусгуулан, Баянхонгор аймагт дотоодын цэргийн ангийн салбар, хэсэг байгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох байгууллагуудад удаа дараа уламжилсны үр дүнд Дотоодын цэргийн штабын 2023 оны 2/2087 дугаар албан бичгээр 2024 онд ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад хүлээн авах боломжтой хариуг ирүүлсэн. Орон нутгаас харуулын бүрэлдэхүүний ажиллах байр, албаны өрөө тасалгаа, холбоо дохиолол, хяналтын камер, инженер-техник хэрэгслээр хангах боломжтой хариуг хүргүүлсэн. Үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр ҮАБЗ-ийн ажлын албан хүргүүлэн ажиллалаа. | |
| 139 | | 5.1.2. Нийтийн эзэмшлийн талбайг камержуулж, засвар үйлчилгээ хийх | | Гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийн хувь | 95 | ОНТ-өөс 20.0 сая/төг-ийг Баянхонгор сумын ГХУСАЗСЗ-ийн төсвөөс 190.0 сая/төг-ийг | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайн 34 цэгт 53 ширхэг хяналтын камерыг суурилуулж, “Ногоон бүс” төслийн хүрээнд 4 цэгт автомашины дугаар танигч, машин, мотоцикл тоологч систем бүхий 4 ширхэг хяналтын камерыг байршуулан, 500 метр шилэн кабель татаж, 5 цэгийн камерын гэмтлийг засварласан байна. Жинст сумд 4 цэгт 9, Галуут сумд 6 цэгт 13, Баацагаан сумд 4 цэгт 10, Жаргалант сумд 4 цэгт 12, Бөмбөгөр сумд 6 цэгт 12 ширхэг нийт 5 сумын 24 цэгт 56 ширхэг хяналтын камерын суурилуулалт хийгдэж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн аймгийн төвд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шалган нэвтрүүлэх байрны Цагдан хорих байрны шалган болон конторт 12 ширхэг камер, байгууллагын гадна хэсэгт 2 ширхэг камер нийт 14 ширхэг телекамер суурилуулж, 5 ширхэг камерыг нөөцөлсөн байна. Камержуулалтыг | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэмэгдүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт 11 сарын байдлаар 45.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 пунктаар өссөн. | |
| 140 | | 5.1.3. Баруун бүсийн наркологийн эмнэлэг барих | | Эмнэлгийн тоо | 1 | | Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/691 дүгээр захирамжаар 9-р багт "Шинэ булаг" 5 гудамж 523 тоот хаягт 39247 м2 газрыг эзэмшүүлж газрын асуудлыг шийдвэрлэсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглосон тул бусад асуудал шийдэгдээгүй болно. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. | 50% |
| 141 | 5.2. Батлан хамгаалах салбар | 5.2.1. Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг зохион байгуулах хөдөлгөөнт сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх | | Сургалтад хамрагдсан цэргийн үүрэгтний тоо | 120 | | Цэргийн штабаас сургалтын материаллаг бааз бүрдүүлэх зорилгоор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний зардалд 20.000.000 төгрөг батлуулан 20 тонны контейнер, зөөврийн сургалтын ширээ, сандал, хээрийн эвхдэг ор зэргийг тус тус бүрдүүлж сургалтад ашиглаж байна. | 50% |
| 142 | | 5.2.2. Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын шатны сургалтуудыг зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | Цэргийн дүйцүүлэх албны мөнгө төлбөр 8.447.200 | Цэргийн дүйцүүлэх албаны “Бэлтгэл шат”-ны сургалтыг 05 дугаар сарын 03-17-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 103 дугаар салбарыг түшиглэн, “Тусгай үүргийн бэлтгэл шатны” сургалтыг 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 09-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хээрийн байрлалд тус тус зохион байгуулан явуулж тайлант онд цэргийн дүйцүүлэх алба хаагчдын шатны сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Сургалтад 2022-2024 онд алба хаах 36 иргэн, 2023-2025 онд цэргийн дүйцүүлэх албыг хаах нийт 20 сумын 40 иргэн хамрагдаж цэргийн дүйцүүлэх алба хаах гэрээг байгуулсан. Мөн дүйцүүлэх алба хаах журмын дагуу орон нутагтаа бүтээн байгуулалтын ажилд үүрэг гүйцэтгэж 16 сая орчим төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | | 5.2.3. Зэвсэгт хүчний 103 дугаар тусгай ротын барилгын гадна засвар хийх | | Засварын ажлын явц, хувиар | 100 | Орон нутгийн төсөв 19.950.000 | Улаанбаатар хотоос барилгын гадна засварын өнгөлгөөний “Сайдинг” нийт 320 ширхэг, зөөлөвч дулаалга 10 боодол, шрүп 60 хайрцаг, бусад шаардлагатай материалыг худалдан авч, ажилчдын орон сууц болох 9х17 хэмжээтэй 2 барилгын гадна засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 144 | | 5.2.4. Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай ротын сантехник, дулааны шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх | | Засварын ажлын явц хувиар | 100 | Орон нутгийн төсөв 19.950.00 сая төгрөг | Зэвсэгт хүчний 143 дугаар салбарын 12 айлын албан тушаалын орон сууцны засварын ажлыг Хонгор инженеринг ХХК хийж гүйцэтгэлээ. орон сууцны хэрэглээний усны 5 тн нөөцийн савыг уурын зууханд холболт хийж, ариун цэврийн өрөө, гал тогоо угаалтуурын шугамыг шинээр сольж засварын ажлыг хийсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 145 | 6.1. Ухаалаг Засаглал | 6.1.1. Иргэдэд зориулсан "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх | | Хамрагдсан өрхийн тоо | 5000 | Жилийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал 35.0 сая төгрөг | "Хамтдаа шийдье" арга хэмжээг "Нээлттэй Баянхонгор" арга хэмжээтэй хамтатган 1000 малчин иргэдийн дунд зохион байгуулж эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлгийн үзлэг, төрийн байгууллагын үйлчилгээг нэг дороос үзүүлж, мөн малчдын тулгамдаж буй асуудал, хамтран нэгдэн нийлж хоршоо бүлгийг байгуулж малын түүх эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, залуу малчдыг бэлтгэх, тэднийг төрөөс бодлогоор дэмжих талаар нэгдсэн чуулга уулзалтыг зохион байгуулж ажилласан. Энэ хүрээнд малчдад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох тэднийг дэмжих, малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогын тодорхойлон дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулсан. | 84% |
| 146 | | 6.1.2.1. bayankhongor.igovernment.gov.mn сайтын нэмэлт хөгжүүлэлт | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 53400,80 | | Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг хөгжүүлэн шинэ 3 систем болон 8 төрлийн засвар үйлчилгээ хийлгэх ашиглалт, үйлчилгээний 2023/А/68 дугаар гэрээг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр байгуулж, тайланг хүлээн авсан. Засвар үйлчилгээ бүрэн хийгдсэн. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний системийг шинээр хийлгэхээр гэрээгээр тохиролцсон боловч Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох журам батлагдаагүй учир систем хийгдээгүй байна. | |
| 147 | | 6.1.2.2. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын албан бичиг төлөвлөлтийг цахимжуулах | | Албан бичиг төлөвлөлтийн цахим хөгжүүлэлтийн хувь | 100 | Орон нутгийн төсөв | 2023 онд https://eoffice.bayanhongor.gov.mn/ системээр нийт 11 байгууллага, 18 сумын төрийн байгууллагад 3262 албан бичгийг цахимаар төлөвлөсөн байна. | 100% |
| 148 | | 6.1.2.3. Үндэсний дата төв УТҮГ-т Баянхонгор аймгийн дэд системүүдийг нэгтгэн сервер компьютер байршуулах | | Сервер компьютер, байршуулсан дэд системийн тоо | 25 | | Big data буюу их өгөгдлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа цахим систем болон өдөр тутмын тоон мэдээллийг боловсруулан нэг цэгт төвлөрүүлж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дашбоард бий болгох зорилгоор 2023 онд орон нутгийн төсвөөс 1ш өндөр хүчин чадалтай dell PowerEdge R750xd сервер компьютерыг худалдан авсан. Тус серверийг Үндэсний Дата төв УТҮГ-т байршуулахаар хүсэлт илгээж, гэрээ байгуулахаар хүлээгдэж байна. | 50% |
| 149 | | 6.1.2.4. Аймгийн цахим мэдээллийн систем болон бусад хэрэгцээнд ашиглах ухаалаг самбар | | 65 инч V5 class Интерактив дэлгэцийн тоо | 4 | Орон нутгийн хөгжлийн сан | Аймгийн цахим мэдээллийн систем болон бусад хэрэгцээнд ашиглах 3ш ухаалаг самбарыг худалдан авах тендерт "САНКАО МАРКЕТИНГ" ХХК шалгарч MAXHUB брэндийн 86 инч дэлгэц 1ш, 65 инч дэлгэ 2 ширхгийг гэрээний дагуу нийлүүлж албан хэрэгцээнд ашиглаж эхлэв.Тоног төхөөрөмжийн хангалтыг хийснээр томоохон хурал цуглаан, зөвлөгөөнийг зохион байгуулахад мэдээ мэдээллийн дамжуулалт, түгээлтийн хурдыг нэмэгдүүлсэн. | 100% |
| 150 | | 6.1.2.5. АЗДТГын Архив бичиг хэрэгт стандарт хангасан сүлжээний хэвлэгчтэй болох | | Шүүгээний тоо | 4 | Орон нутгийн төсөв | Аймгийн Засаг даргын тамгын газрын архив бичиг хэрэгт стандарт хангасан сүлжээний олон үйлдэлт хэвлэгчтэй болсон. Тоног төхөөрөмжөөр хаагдсанаар архив бичиг хэргийн үйл ажиллагаа шуурхай болсон | 100% |
| 151 | | 6.1.2.6. Архивын улсын үзлэг угтах ажлын хүрээнд нягтруулах шүүгээ | | Шүүгээний тоо | 4 | | Архивын улсын үзлэг угтах ажлын хүрээнд 8 нягтруулах шүүгээтэй болсон. Стандартын шаардлага хангасан шүүгээтэй болсноор байгууллагын архивын хадгалалт хамгаалалт сайжирсан. | 100% |
| 152 | | 6.1.2.7. Аймгийн ЗДТГ хэвлэлийн мэдээллийн алба, | | Гэрээний хэрэгжилтийн хувь | 100 | | 2023 онд Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд 31,449,000 сая төгрөгийн 20 нэр төрлийн тоног төхөөрөмж, Аймгийн Засаг даргын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хурлын залны тоног төхөөрөмж | | | | | Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албанд 26,951,000 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Тамгын газрын албан хаагчдын тоног төхөөрөмжийн чадлыг сайжруулахад 41,600,000 сая төгрөгийн суурин компьютерыг тус тус шинэчлэн албан хаагчдыг бүтээмжийг нэмэгдүүлж, шуурхай байдлыг хангаад байна. | |
| 153 | | 6.1.2.8. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн цахим үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулж, үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн өрөө байгуулж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах | | Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 9188 | | Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төрийн цахим үйлчилгээний e-mongolia.mn системээр дамжуулан Баянхонгор аймгийн 31 үйлчилгээ угсрагдсан бөгөөд эдгээр нь ХУР, ДАН системээр дамжуулан иргэд лавлагаа тодорхойлолт, тусгай зөвшөөрөл авч байна. Мөн төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх "ХУРДАН" цэгийг аймгийн Засаг даргын тамгын газар, Баруун бүсийн худалдааны төв. Нэгдсэн эмнэлгийн амбулатори байранд тус тус 3 цэг шинээр байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 сарын байдлаар 16,000 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. | 100% |
| 154 | | 6.1.3.1. "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | 85 | | "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/271 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа үндэсний хөдөлгөөний зорилго зорилтот нийцүүлэн, харъяа салбар байгууллагуудаас 2 удаагийн санал авч нэгтгэн, “Эрүүл иргэн- Хонгорын баялаг” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар батлан хэрэгжилтийг зохион байгуулж байна. “Эрүүл мэндийнхээ төлөө цаг гаргая” аяныг 2023 оны 04 дүгээр 13-наас 06 дугаар сарын 24-ний хооронд зохион байгуулж, 20 сум, 62 байгууллагын давхардсан тоогоор 17,000 иргэн хамруулж, сумдын биеийн тамирын арга зүйч багш нарт үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр заавар чиглэл хүргэж арга зүйгээр ханган ажилласан.Арга хэмжээний төлөвлөгөөний дагуу анхан болон хоёрдогч шатлалын 26 эрүүл мэндийн нэгж Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээ, Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд 2023 оны 11 сарын байдлаар 26 тэмдэглэлт өдрийг зохион байгуулж, аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 52289 иргэнийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд хамруулсан. Үүнээс сургуулийн өмнөх насны- 2580 /4.9%/, Өсвөр насны хүүхэд- 6216 /11.9%/, Оюутан- 2050 /3.9%/, Албан хаагч- 5768 /11.4%/, Малчин иргэд- 10192 /19.5%/, Ажилгүй иргэд- 3515 /6.7%/, Хувиараа хөдөлмөр эрхлэгчид- 6877 /13.1%/, Бусад- 14968 /28.6%/ иргэн хамрагдсанаас, мэдлэгийн түвшин 56.5 хувиар нэмэгдсэн. "Түмэн дасгал" буюу япон хүн бүрийн эрүүл амьдралын үндэс болсон тайсо-дасгалыг 18 албан байгууллага, 3 суманд зааж сурган, 7 байгууллага, 8 сум ажлын байрны дасгалыг хийж хэвшүүлээд байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. | |
| 155 | | 6.1.3.2. "Соёлтой Баянхонгорчууд" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Хэрэгжил тийн хувь | 70 | | Бүх нийтийн соёлын боловсролд чиглэсэн 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээр "Соёлын сэргэлт", "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд залуучууд-20, Гэр бүл-10, ахмад настан 10 нийт 50 хүнийг "Соёлын хөтөч"-өөр бэлтгэж, соёл, урлагийн 24 байгууллага "Соёлын боловсрол"-ын хөтөлбөр боловсруулан баталж хэрэгжилтийг хангaн ажиллаж байна. Аймгийн төвийн 6 сургууль, 19 сумын сургуулиудад нийт 13-17 насны 268 сурагчийг Соёлын боловсролын үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн. Соёл урлагийн байгууллагуудаас аймгийн хэмжээнд 115 соёл, урлагийн болон соён гэгээрлийн арга хэмжээг зохион байгуулж 16720 хүнд хүрч ажиллан 10.7 сая төгрөг зарцуулж ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 70 хувьтай байна. | 100% |
| 156 | | 6.1.3.3. Эрүүл амьдрал - Идэвхтэй хөдөлгөөн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | Төлөвлө гөөний хэрэгжил тийн хувь | 50 | | "Эрүүл иргэн- Хонгорын баялаг" арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын 2023 оны А/554 дүгээр захирамжаар батлан хэрэгжилтийг зохион байгуулж "Эрүүл мэндийнхээ төлөө цаг гаргая" аяныг 2023 оны 04 дүгээр 13-наас 06 дугаар сарын 24-ний хооронд зохион байгуулж 20 сум, 62 байгууллагын давхардсан тоогоор 17,000 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэн хамруулж сумдын биеийн тамирын арга зүйч багш нарт үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр заавар чиглэл хүргэж арга зүйгээр ханган ажилласан. Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд, 16 үйл ажиллагаа төлөвлөн 97 хувьтай хэрэгжүүлсэн. | |
| 157 | | 6.1.3.4. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх | | Арга хэмжээний хэрэгжил тийн хувь | 07 | | Аймгийн Засаг даргын захирамжаар " Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөө" -баталж 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 92 хувьтай байна. Багшийн тасралтгүй хөгжлийг хангах зорилгоор “Мэргэжлийн бүлгийн зохион байгуулалтаар хамтран ажиллах арга зүй” сургалтыг 1200 гаруй багш ажилтанд зохион байгуулж үүний үр дүнд 130 гаруй мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдан ажиллаж байна. Мэргэжил дээшлүүлэх, цахим контент боловсруулах арга зүйн сургалтыг 800 гаруй багшид зохион байгуулснаар 311 цагийн онлайн хичээл бүтээж үндэсний цахим санд байршуулсан. “Сургуулийн менежментийг сайжруулах хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслахад дэмжлэг үзүүлэх, Орон нутгаас “Сургуульд суурилсан менежментийг хэрэгжүүлэх, үнэлгээ хариуцсан менежерүүдийн чадавхжуулах хөтөлбөр, төрөлжсөн хичээлүүдийн улсын олимпиад, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш нарт 2021-2023 онд 100.0 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 600 багшид өндөр хурдны зөөврийн компьютер олгоход 1,4 тэрбум төг, дижитал анги 14 сургуульд байгуулахад 900.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн . | 90% |
| 158 | | 6.1.3.5. Сурагчдын хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Сургалтын амжилтын өсөлтийн хувиар | 20 | | Ковидын дараах сурлагын хоцрогдол нөхөх арилгах төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд төлөвлөсөн. Үүнд. 1. 2021 оны эхэнд сургууль завсардах магадлалтай 84 сурагч байсныг сургуульдаа эргэн суралцах боломжоор бүрэн хангаж өгснөөр сургууль завсардалт гараагүй. Нийт 30 сургуулийн 50 хувьд орон сэтгэл зүйч ажиллаж, хоцрогдол арилгахад эцэг эх, сургуулийн зөвлөлийн үүрэг оролцоог нэмэгдүүлж цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлсэн. Сургуульд суурилсан үнэлгээнээс | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурлагын амжилтыг 20 болон түүнээс илүү хувь ахиулсан 5 багшийг шалгаруулж урамшуулсан. 2. 2022 онд 600 багшид 2023 онд дахин 600 багшид өндөр үзүүлэлттэй зөөврийн компьютерийг олгосон. БШУГ болон 6 сургуульд 21 сая төгрөгийн цахим сургалтын лаборатори, 650 сая төгрөгийн үнэтэй таблет бүхий цахим хэрэглэгдэхүүнээр 6 сургуулийг хангасан байна. Багш нар 265 цагийн контент бүтээж, 30000 гаруй тестийн сан бүрдүүлсэн Сурлагын хоцрогдол нөхөх, арилгахад 13 сургууль тус бүрд нийт 77 дэмжигч, 5 сургууль 38 явуулын, 8 дадлагын багшийг ажиллуулсан байна. Зуны сургалтанд 219 багш хамрагдсан. Дотуур байрын багшийн үйл ажиллагааг Сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад чиглүүлэн ажиллав. ЕБС-д 101, СӨБ-д 46, насан туршийн боловсролд 52, “ХБХХөгжүүлэх төв”-д 25 нийт 224 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нь аймгийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 46,5 хувийг эзэлж байна. Үүнээс ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хичээллэж байгаа 48 хүүхэд байна Хоцрогдол арилгаж буй сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш солилцоо, сургалт 10 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, багшийг Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах арга зүйгээр хангаж ажилласан. Сургуулийн менежментийг сайжруулах, үр дүнд суурилсан төлөвлөлтийг хийхэд сургууль цэцэрлэг бүрт сургалт явуулах, зөвлөн туслах, бусад сургуулийн сайн арга зүйгээс суралцах үйл ажиллагаа арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Үүний үр дүнд сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын хэмжээнд 1 байранд эрэмбэлэгдлээ. | |
| 159 | | 6.1.3.6. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 75 | | "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 98 хувьтай хэрэгжсэн. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийсэн зөв зохистой хооллолт, эрхтэн тогтолцооны хөгжил алдагдахаас урьдчилан сэргийлэх, бичил тэжээлийн дутагдлаас урьдчилан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж нийт 4987 хүнд эрүүл хооллолтын зөв дадлыг төлөвшүүлэхэд нөлөөлж ажилласан.Олон улсын Эко-сургууль /цэцэрлэгүүдэд/ зориулсан Ахисан шатны 3 дахь сургалтанд амжилттай хамрагдаж Баянхонгор сумын 5,10,13,16-р цэцэрлэг, Шинэжинст, Бууцагаан сумдын цэцэрлэгүүд амжилттай хамрагдсан."Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Энэ ажлын хүрээнд 7000 гаруй хүүхдэд байгаль дэлхийгээ хайрлах төлөвшлийг олгож дадал хэвшил болгоходанхаарч ажиллаж байна. "МӨНГӨН ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 3, 6, 7, 12, Гурванбулаг сумын цэцэрлэг, "ХҮРЭЛ ГЭРЭГЭ" өргөмжлөлийн болзол хангасан Баянхонгор сумын 5, 10, 13, 16, Өлзийт, Бууцагаан, Шинэжинст сумын цэцэрлэгүүд өргөмжлөлөө хүлээн авсан. мэргэжил арга зүйгээр хангахад чиглэгдсэн ISO14001 стандартыг сургалтын хөтөлбөртөө тусган ажилласан. | |
| 160 | | 6.1.3.7. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | 100 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр 18 төрлийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 14662 залуучуудад хүрч ажилласан. Үүнд: 1.“Ирээдүйн ээзд 2023” мэргэжил сонголтын аяны хүрээнд – 815 сурагч 2. “Нэг хамт олон - Нэг сайн дурын ажил” нөлөөллийн аянд 35 аж ахуй нэгж, албан байгууллагын 3210 иргэн 3.Нэг тэрбумаараа тэмцье-2023” аяны хүрээнд 250 иргэн 4. “Хамтдаа хөгжиж хамтдаа хамгаалъя нэгдсэн өдөрлөг” арга хэмжээнд – 190 өсвөр үе, залуучууд 5. Амьдрах ухааны 11 модуль сургалтад – 1620 иргэн 6. “Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал” арга хэмжээнд – 320 иргэн 7.Монголын залуучуудын холбоотой хамтран “Залуучуудаа сонсъё” аяны хүрээнд 12 сумын 2426 залуу 8.“Бид хонгорын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | залуус-2023” залуучуудын нэгдсэн чуулганд 250 гаруй залуус 9.Байнгын ажлын байранд 235, түр ажлын байранд 591 залууг холбон зуучилсан 10. Залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан “Төрийн бус байгууллагын стратеги” сэдэвт сургалтад 12 ТББ-ын төлөөлөл 36 залуу 11.Шийдвэр гаргах болон бодлого боловсруулах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх бодлогын хэлэлцүүлэгт шийдвэр гаргагчид, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөл нийт 38 залуу 12.Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд 2295 залуу, 13.Эх оронч залуу арга хэмжээний хүрээнд цэргийн ангийн 236 албан хаагч, 14.Монгол Улсын “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээнд 150 хүн 15.Баянхонгор сумын сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг танхимыг түшиглэн 550 өсвөр үе залуучуудад үйлчилгээг үзүүлсэн 16. Өлзийт, Гурванбулаг, Хүрээмарал, Галуут, Богд, Шинэжинст, Баянговь, Баянлиг сумдууд орон нутагтаа Залуучуудын чуулга уулзалтад 1320 залуучууд оролцсон 17.”Залуучуудын манлайлал” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулж 5 бүтээлээр 10 оюутан, залуус оролцов. 18.Гэрлэх ёслолын ордонд хуримаа хийж буй 60 хос буюу 120 иргэнд сургалт зохион байгуулсан.Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. | |
| 161 | | 6.1.3.8. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70 | | "Хүүхдэд ээлтэй орон нутаг" санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөнд нийт 12-15 ажил арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: -Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлыг танхимаар 1 удаа зохион байгуулж 14 гишүүнийг хамруулсан. Сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийн 114 гишүүдийг 1-2 удаа арга зүйгээр хангаж ажилласан. Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байгаа албан байгууллагын тоо боловсролын салбарт 121, бусад салбарт 42 байна. Аймгийн хэмжээний 115 төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдэд эцэг эхийн зөвлөл байгуулан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллах, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг өгч эргэн хяналт тавьж ажилласан. Мөн 25 байгууллагад хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Эцэг эхийн зөвлөлтэй төрийн байгууллагын тоо 175, аж ахуйн нэгж-14, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж байгаа 215 байгууллага байна. Гэрлэх ёслолын ордонд "Гэр бүлд зөвлөгөө өгөх" төвийг байгуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж байна. Сумдын хамтарсан багуудад зөвлөн туслах ажлыг 6 удаа зохион байгуулсан. Нийт 29 хамтарсан багт 373 гишүүн ажиллаж байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 15 гишүүнтэйгээр ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 сүм, хийдэд шавилан сууж байгаа 37лламхай хүүхдүүдийн нөхцөл байдал, эрх хамгаалал хяналт шалгалтыг зохион байгуулж, газар дээр зөвлөн тусалсан. 2023 оны байдлаар 20 бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд байгаагийн 11 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж хохирогч хүүхэд бүрд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна. Боловсролын салбарын Хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг нийт 3 удаа зохион байгуулж 970 хүнийг хамруулан зохион байгуулсан. Газар дээр нь зөвлөн туслах, арга зүйг олгох ажлыг нийт 35 цэцэрлэг, 23 сургууль, 20 дотуур байрын багш ажилтнуудад зохион байгуулсан.Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай. | |
| 162 | | 6.1.3.9. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллалд хамтдаа" 5Х-ийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | | "5Х"-гийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, аяны хүрээнд 8 төрлийн сургалт 4 төрлийн нөлөөллийн ажил зохион байгуулж 6581 албан хаагч, эцэг эхчүүдийг хамруулсан. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, "Хөөрхөн зүрх" ТББ-тай хамтран зохион байгуулсан сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгөх арга зүйн сургалтад 32, цахимаар зохион байгуулагдсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх анхан шатны арга техник болох "Зурган оношлогоо" арга зүйн сургалтад 29 нийгмийн ажилтан, 43 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цэцэрлэгийн арга зүйчид, Монголын Хүүхэд, гэр бүл судлалын академийн тэргүүн, МУ-ын гавьяат багш, доктор доктор(Ph.D), дэд профессор, хүүхэд, гэр бүл, судлаач Х.Баавгайтай хамтран “Миний гэр бүл”, “Миний ертөнц” хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан сургуулийн сурагчдын асран хамгаалагч гэр бүл, хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах сургалтад 25 нийгмийн ажилтныг хамруулж, чадавхжуулсан. Арга хэмжээний хүрээнд “Хүүхэд хамгааллын баг” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын 31 багийн үйл ажиллагаа, сургуулийн хүүхэд хамгааллын 34 багийн үйл ажиллагаанд хүүхдэд ээлтэй орчин, багш нарын мэдлэг, ур чадвар, хамтын ажиллагаа, шинийг санаачлан үр дүнд хүрсэн зэрэг шалгуур үзүүлэлтээр дүгнэж, Цэцэрлэгийн шилдэг багаар нэгдүгээр байр Баянхонгор сумын 15-р цэцэрлэг, хоёрдугаар байр Гурванбулаг сумын цэцэрлэг, гуравдугаар байр Богд сумын цэцэрлэг, сургуулийн шилдэг багаар нэгдүгээр байр Богд сумын сургууль, хоёрдугаар байр Баянцагаан сумын сургууль, гуравдугаар байр Хүрээмарал сумын сургууль тус тус шалгарч, шагнаж урамшуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай. | |
| 163 | | 6.1.3.10. "Эрүүл өсвөр үе бидний ирээдүй" төсөлт арга хэмжээ хэрэгжүүлэх | | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 60 | | Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх өсвөр үеийн кабинет нь 2020 оноос өсвөр үеийн хүүхдүүдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, үзлэгт хамруулах зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулж ирсэн. Кабинет нь сургуулиудын өсвөрийн эмч клуб, ГБХЗХГ, улаан загалмайн хороо, сум, багийн эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүд, нийгмийн ажилтануудтай хамтран нийт 12 удаагийн сургалт мэдээллийн ажлыг хийсэн. Энэ онд нийт өсвөр насны 1051 хүүхдийг үзлэгт хамруулж, урьдчилан сэргийлэх үзлэгт-816, зөвлөгөө мэдээлэлд 116 хүүхэд, хамрагдсан ба бэлгийн замын халдвар-22-ийг илрүүлж, эмчилгээнд хамруулсан, хүчирхийлэлд өртсөн-13 хүүхэд, Богд, Өлзийт сумдад үзлэг хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 164 | | 6.1.3.11. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 55 | | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 24 арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн Засаг даргын 2022 оны А/265 захирамжаар батлуулан сумдад хүргэсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж нийт 6735 хүнд хүрсэн байна. Сургалтанд хамрагдсан иргэдийг хүйсээр ангилвал эрэгтэй 2753, эмэгтэй 3982 байна. ГХУСАЗСЗ, ЦГ-тай хамтран зохион байгуулсан "Амар тайван гэр бүл" нэгдсэн өдөрлөгийн хүрээнд сумдад ажиллахдаа 2022 онд "Гэр бүлийн боловсрол олгох" сургалтын сургагч багшаар бэлтгэгдсэн 48 хүнийг идэвхжүүлэх, дадлагажуулах ажлыг зохион байгууллаа. "Хуримын ордон" 2023 оны 03 дугаар сард ашиглалтад орж "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Зөвлөгөө өгөх төвөөр 201 хүн үйлчлүүлж ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө авсан байна. Мөн сумдад гэр бүлтэй ажиллах нийгмийн бодлогын ажилтнуудыг чадавхжуулах,арга зүйгээр хангах ажлыг 2 удаа, аймгийн төвийн II, III, IX багуудад ажиллаж буй "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-ийг үнэлэх ажлыг 1 удаа, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээрх 8 төрлийн шторкийг байгууллагын цахим хуудсаар 2 удаагийн давтамжтай цацах ажлыг тус тус зохион байгуулсан байна. Төлөвлөгөөний биелэлт 50% байна. | 91% |
| 165 | | 6.1.3.12. "Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем"-ийг цахим хэлбэрт шилжүүлэх | | Төрийн сангийн гүйлгээний цахим нэвтрэлтийн хувь | 80 | Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | Аймгийн Засаг даргын 2023 оны А/31 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд төрийн сангийн 21 нэгжийн 189 төсөвт байгууллагуудын төлбөр тооцоо "Төрийн сангийн удирдлагын цахим систем"-д 100 хувь амжилттай шилжсэн. Тус цахим шилжилтийн хүрээнд "Шилдэг цахим санхүүгийн алба" уралдааныг 2023 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Тус уралдааны хүрээнд 5 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд оролцсон 20 сумын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарын нийт 28 хүнийг хамруулан тайланг хэлэлцүүлж, сургалт зөвлөгөөг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгч, дүгнэж ажиллав. “Шилдэг цахим санхүүгийн албаар Баянлиг, Гурванбулаг, Өлзийт, Галуут сумдын санхүүгийн алба байр эзэлж, бусдыгаа манлайлан ажилласан. Тус уралдааныг зохион байгуулсны үр дүнд шинэ цахим системүүдэд шилжихтэй холбоотой сум тус бүрийн байгууллагуудын дарга, нягтлан бодогчид, төрийн сангийн мэргэжилтнүүдээс ирэх асуултууд, системийн алдааны тоо эрс буурсан. Мөн аймгийн төвийн нийт 80 нягтлан бодогчдын дунд"Төрийн сангийн цахим шинэчлэл" сэдэвт мэдлэг чадвар дээшлүүлэх, авхаалж самбаа сорьсон асуулт хариултын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Дээрх 2 уралдааны тэмцээнийг зохион байгуулсны үр дүнд төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт цахим байдлаар үнэн зөв хэрэгжиж, анхан шатны баримтын хяналт, бүрдүүлэлт сайжирсан, цаашид урам зоригтой ажиллах эрч хүч, санхүүгийн зөрчил бууруулах, ажлын үр дүн нэмэгдүүлэх шинэ санаа санаачилга гаргаж, хэрэгжүүлж байгаа явдал юм. Мөн тус уралдаан тэмцээнийг зохион байгуулж, интернэт орчинд байршуулж, төрийн сангийн цахим шилжилт, төсвийн шинэчлэлийг сурталчилж, санхүүгийн ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн нь бусад аймаг нийслэлийн төрийн сангуудыг манлайлж ажилласан онцлогтой байв. | |
| 166 | | 6.1.3.13. Баянхонгор аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталсан. Тус хөтөлбөрийг энэ онд 79,6 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тогтолцоог аймгийн хэмжээнд нэвтрүүлж ажиллаж байна. Энэ онд шинээр 14 сум 94 ширхэг ангилан ялгах хогийн сав байршуулсан. Баян-Өндөр, Баянцагаан, Галуут сумдад хоёрдогч түүхий эд худалдан авч, борлуулдаг иргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн."Хог биш ээ баялаг" ТББ хамтран "Хог | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийн хүрээнд Баянхонгор сумын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарт "Багаас нь зааж сургая", ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах бүлгийн сурагчдад "Хүүхдүүд хогны ертөнцийг өөрчилж чадна" "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨТҮГ, "Цэвэр хот" ОНӨААТҮГазрын удирдлага, албан хаагчдад "Баянхонгорын ногоон баялаг бүтээгчдийг дэмжих нь" Баянхонгор сумын иргэдэд "Баянхонгорын хогийг баялаг болгоход иргэн бүрийн оролцоо нэн чухал" сэдэвт сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулсан. Мөн "Цэвэр хот" ОНӨААТҮГазрын хог ангилан ялгаж тээвэрлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 8 тн пресслэгч машин, 15 ширхэг чанга яригчийг худалдан авсан. | |
| 167 | | 6.1.3.14. Аймгийн тээврийн салбарын бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | 100 | | Тус ажлыг "Ати консалтинг" ХХК-тай гэрээ байгуулж Баянхонгор аймгийн тээврийн салбарын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Аймгийн ИТХ-аар хараахан батлуулаагүй байна. | 50% |
| 168 | | 6.1.3.15. "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 3" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 80 | | 2023 онд Хоршоологчдын аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, сум орон нутагт үйл ажиллагаа эрхлэгч хоршоодыг чадавхжуулах, аймгийн хэмжээнд бүртгэлтэй 207 хоршоо хэвийн үйл ажиллагаа явуулж буйгаас 144 хоршоог үнэлгээнд хамруулж, хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 13 сумын 57 ААН, иргэнд 1.109 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байна. Ажлын байр 53-аар нэмэгдсэн. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 83.3 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 169 | | 6.1.3.16. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | Сургалтад хамрагдагсдын тоо | 1600 | Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 10,0 сая төгрөг | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар батлан, 100 хувьтай хэрэгжсэн байна.Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 55 байгууллагын 18550 гаруй иргэд, төрийн албан хаагч, сурагчдад төлөвлөгөөт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажилласан.20 хууль тогтоомжоор 70 гаруй төрлийн постер, 43 төрлийн гарын авлага бэлтгэж, 800000 гарын авлагыг иргэдэд түгээж, орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар тогтмол сурталчлан, иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа. Мөн шинэчлэн найруулга хийгдэх 6 хууль, 4 журам, аймгийн ИТХ-ын 1 тогтоол, 1 захирамжийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг 15 удаа зохион тушаалтанд хүргүүлэн ажилласан.Аймгийн хэмжээнд эрх зүйн хөтчөөр бэлтгэгдэн идэвхтэй ажиллаж байгаа 167 албан хаагчдаас 55 эрх зүйн хөтчийг цахим болон тахимын хэлбэрээр давтан сургах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 16,17-ний өдрүүдэд зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажилласан. Эдгээр сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшилсэн. | |
| 170 | | 6.1.3.17. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж шударга байдлын түвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын түвшинг ахиулах арга хэмжээг зохион байгуулах | | Авлигын гэмт хэргийн тоо Шударга байдлын үнэлгээний хувь Цахим хуудасны ил тод байдлын хувь | 2 72 48 | Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 8.0 сая төгрөг | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/48 дугаар захирамжаар 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөн биелэлтийг 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. Авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд аймгийн хэмжээнд 10 төрлийн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж 126 сум, байгууллагын 17000 иргэн, төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл хийж, Авлигын эсрэг хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжоор 25 төрлийн постер, 9 төрлийн видео, 15 төрлийн гарын авлагыг хийж нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд авлигын эсрэг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлуудыг үе шаттай зохион байгуулсны үр дүнд аймгийн цахим хуудасны үнэлгээ 2022 онд | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 67,01 хувьтай байсан бол 2023 оны байдлаар 89,01 хувь болж 22 хувиар өссөн. Авлигын гэмт хэрэг 2022 онд 15 бүртгэгдэж байсан бол энэ оны 11 сарын байдлаар 14 бүртгэгдэж өмнөх оноос 1 нэгжээр буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 171 | | 6.1.3.18. “Зөв-Амьдрал” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах | | Хэрэгжилтийн хувь | 100 | Орон нутгийн төсвөөс 5.0 сая/төг- | “Зөв амьдрал”дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 2023 оны А/33 дугаар захирамжаар батлуулан, биелэлт 100 хувьтай. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох журмаар давхардсан тоогоор 810 худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт цахимаар болон танхимын сургалтыг зохион байгуулж, 430 аж ахуйн нэгжид 4 төрлийн 1720 гарын авлагыг түгээж ажиллалаа. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах төлөвлөгөөг батлан 100 хувьтай биелсэн. Тус хуулийн хүрээнд ХХААХҮЯ-наас ирүүлсэн 2 журмын төсөлд санал хүргүүлэн ажилласан. Шүүхийн шийтгэврээр баривчлагдсан 551, эрүүлжүүлэгдсэн 86, албадан саатуулагдсан 334 этгээдэд 174 удаагийн 502 цагийн сургалтыг давхардсан тоогоор 3021 этгээд, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 145 удаагийн 294 цагийн сургалтыг 10346 иргэн, төрийн албан хаагчдад тус тус зохион байгууллаа.Мөн “Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг шаардах нь хуулиар хориглосон үйлдэл "би ч нэгдэнэ, та ч бас нэгд" challenge-ийг өрнүүлж, 30 байгууллагын 700 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Тус хуулийн 27.2, 28.2 дахь заалтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл бүхий масс мессежийг юнителийн 16110 хэрэглэгчдэд илгээсэн. Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн хариуцлагатай үйлчилгээний ажилтныг сургалтад хамруулж, гэрээ байгуулан, 20 аж ахуйн нэгжийн 35 ажилтныг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамруулаад байна. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 11 сарын байдлаар 107 бүртгэгдэж 4 нэгжээр, зөрчил 1512 бүртгэгдэж 267 нэгжээр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 172 | | 6.1.3.19. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах | | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 95 | Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 5.0 сая төгрөг | Аймгийн Засаг даргын 2023 оны А/145 дугаар захирамжаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөлийн төлөвлөгөөг батлуулж 100 хувьтай хэрэгжилтийг ханган ажиллаж, энэ төрлийн гэмт хэрэг гаралт өмнөх онтой харьцуулахад ижил төвшинд байна. | 100% |
| 173 | | 6.1.3.20. Төрийн архивын сан хөмрөгийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | | Иж бүрэн нягтлан шалгаж дахин боловсруулсан баримтын тоо | 1500 | | Аймгийн Засаг даргын 2023 оны А/51 дүгээр захирамжаар “Төрийн архивын баримтыг иж бүрэн нягтлан шалгах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталснаар 15 байгууллагын 1070 нэгж баримтын 29142 хуудсанд иж бүрэн нягтлан шалгалт хийх ажлыг зохион байгуулан эмхлэн цэгцэлж цахим санд шилжүүлэн хамгаалах хайрцгаар хангаж 100 хувьтай. | 70% |
| 174 | | 6.1.3.21. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх, бүх нийтийн боловсролыг дэмжих | | Хэрэгжилтийн хувь | 70 | | Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Мэргэжлийн холбоод, Иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэх, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоог урамшуулах ажлыг зохион байгуулсан. Хүүхэд залуучуудыг оролцоог дэмжих зорилгоор Карл Попперийн мэтгэлцээний сургалт, "Нэг хүүхэд, нэг нүүдэл" төслийг амжилттай хэрэгжүүллээ | 100% |
| 175 | | 6.1.4.1. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах | | Сургалтад хамрагдагсдын тоо | 2 | | “Хууль дээдлэх ёс” ТББ-тай сургалтын гэрээ байгуулан сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд зохион байгуулж 4 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 176 | | 6.1.4.2. Архив, бичиг хэргийн мэргэжилтэй | | Шинээр элсүүлэх | 20 25 | | Аймгийн төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтанд төлөвлөгөөт 62 сургалтыг | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын архив албан хэрэг хөтлөлтийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | | ажилтны тоо Төгссөн ажилтны тоо | | | “Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл” сэдвээр хийж 712 ажилтан хамруулж 12 төрлийн мөрдөх ажлын үүрэг чиглэл өгч арга зүйгээр хангасан. Мөн Захиалгаар нийт 35 байгууллагын 598 удирдах болон гүйцэтгэх ажилтанд Архив, албан хэрэг хөтлөлтийн онлайн болон танхимын 35 удаагийн сургалт хийж ажиллалаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлын хүрээнд Түүх архивын "Тэнгэр дээд" сургуультай хамтарч шинээр элсэлт зохион байгуулж 2023 онд нийт 21 архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэсэн. | |
| 177 | | 6.1.4.3. Эрүүл мэндийн салбарын "Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн бодлого төлөвлөлт" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | | Эрүүл мэндийн салбарын "Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн бодлого төлөвлөлт" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/580 дугаар захирамжаар батлан, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Уг төлөвлөгөөний хүрээнд Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг бэлтгэх тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/552 дугаар захирамжаар Анхан шатны эрүүл мэндийн удирдлага, Эрүүл мэндийн бодлого, удирдлага, Нийгмийн эрүүл мэндийн судлаач, эрүүл ахуйч, сувилагч зэрэг 4 мэргэжлээр 10 хүнийг сургахаар сургалт эрхлэх байгууллагуудтай гэрээ хийж, төлбөрийн дэмжлэгийг үзүүлсэн. Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлын байрны тасралтгүй сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 90, “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай байна. | 100% |
| 178 | | 6.1.4.4. Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах | | Мэргэжилтэй боловсон хүчний хангалтын хувь Чадавхжуулсан албан хаагчдын тоо | 70 170 | Жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 26,0 сая төгрөг | Соёл, урлагийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 4 удаагийн сургалт зохион байгуулж, нийт соёл урлагийн 408 ажилтан албан хаагчийг хамруулж чадавхжуулсан. Орон нутгийн төсвөөс мэргэжлийн хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор соёлын салбарын ажилтан албан хаагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж 2023 онд 4 хүнд 9.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн хүний нөөцийн хангалт 70 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хувьтай байна. | |
| 179 | | 6.1.4.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах боловсон хүчнийг сургаж, бэлтгэх /Богино болон урт хугацааны сургалтад ажилтан бэлтгэх/ | | Суралцагчийн тоо | 5 | Орон нутгийн төсөв | Баянхонгор аймаг болон БНХАУ-ын Ганьсү мужтай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 5 мэргэжилтнийг газар тариалан, хүлэмжийн чиглэлээр, ингэний сүүний үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр холбогдох мэргэжилтэн, малчдыг туршлага судлах зэргээр тус тус сургасан. Жючуан хотын техник технологийн сургуульд тус салбарын чиглэлээр аймгийн 20 оюутныг Ганьсү мужийн болон БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр сургаж байна.Түүнчлэн Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, сургаж дадлагажуулах зорилгоор танхимын болон цахим хэлбэрийг хослуулан 26 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 652 иргэн, аж ахуй нэгжийг хамруулсан.Мөн сүлжиж, нэхэх буюу холбоос оёдол гүйцэтгэх захиалгат ажлыг аймагтаа эхлүүлэхээр сүлжих, нэхэх сонирхолтой өөрсдөдөө ажлын байр гаргаж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй 50 хүнийг кетиль оёдолчноор сургах ажлыг 2024.01.02-ноос эхлүүлэхээр, бүртгэл явагдаж байна. Мөн хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдыг чадавхжуулах, мэдээ мэдээллээр хангах чиглэлээр сургалт, зөвлөгөөн, туршлага солилцох уулзалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 11907 хүнийг хамруулсан байна. | 100% |
| 180 | | 6.1.4.6. Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх /Оюутнуудын сургалтын төлбөрийн дэмжлэг/ | | Суралцагчийн тоо | 19 | Орон нутгийн төсөв 27,0 сая төгрөг | Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлсэн. 2022-2023 оны хичээлийн жилд агрономич 1, малын их эмч 5, мал зүйч буюу зоотехинкчээр 11 оюутан нийт 17 оюутан суралцахаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Өнгөрсөн хавар төгссөн 1 оюутан Баянбулаг сумын Хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байна. Ирэх хавар 3 оюутан төгсөж сум орон нутагтаа ажиллана. | 90% |
| 181 | | 6.1.4.7. Нягтлан бодох бүртгэл | | НББ хөтлөлтийн | 90 | Хөгжлийн төлөвлөгөө | Аймгийн засаг даргын А/209 дүгээр захирамжаар Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аймгийн үзлэгийг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтлөлтийн аймгийн үзлэг зохион байгуулах | | хувь | | хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 12,0 сая төгрөг | удирдан зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж 23 арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Арга хэмжээний үр дүнд 196 нягтлан бодогч, санхүүгийн ажилтан хамрагдаж төрийн сангийн цахим шилжилттэй холбоотой хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл сайжирсан, анхан шатны бүртгэл хөтлөлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт стандартын түвшинд 90 хувьд хүрсэн. | |
| 182 | | 6.1.4.8. Аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | | Баянхонгор аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимаас аймгийн өрсөлдөх чадварын судалгааг 12 салбарын 55 аж ахуйн нэгжээс авч, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд хүргүүлсэн. Үндэсний хэмжээнд тус судалгааны үр дүн нэгтгэгдэж, мэдээлэгдээгүй байна. Бизнес орчны судалгааны танилцуулгыг Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан "Invest Bayankhongor" арга хэмжээний үеэр танилцуулсан. | 90% |
| 183 | | 6.1.4.9. Аймгийн хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хүний нөөцийг бэлтгэх нэгдсэн бодлоготой болох | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 15.0 сая төгрөг | Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн судалгаа хийх ажлын гэрээг Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар танхимтай байгуулж, судалгааны ажил хийгдэж дууссан. | 100% |
| 184 | | 6.1.4.10. Төсвийн ил тод байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зорилготой "Иргэдийн төсөв"-Баянхонгор товхимолыг боловсруулан хэвлүүлэх | | Хэвлүүлсэн товхимолын тоо | 1000 | Орон нутгийн төсөв | Дэлхийн банк Швейцарын хөгжлийн агентлаг, MASAM-2 төслийн санхүүжилтээр Баянхонгор аймгийн 2023 оны төсвөөр Иргэдийн төсвийг бэлтгэн аймгийн албан ёсны вэбсайт, фэйж хуудсуудаар нийтэд мэдээлж, Силвер Жанго компаниар 800 ширхгийг орон нутгийн төсвийн 4,0 сая төгрөгийн өртөгтэйгээр хэвлүүлэн аймгийн хэмжээний 105 багийн иргэдэд тараасан. | 80% |
| 185 | | 6.1.5.1. Эрүүл | | Хэрэгжилтий | 74 | | Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд ЭМД-ын сангаас гүйцэтгэлээр санхүүжих өрх, сумын ЭМТ-ийн төсөв захирагч болон санхүүгийн ажилтнуудад танхимын болон цахим сургалт зохион байгуулах | | н хувь | | | шинэчлэлийн хүрээнд зохион байгуулагдах сургалт арга хэмжээг “Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт” сэдвээр зохион байгуулж, сумдын Эрүүл мэндийн төвийн дарга, статистикч эмч, нягтлан бодогч, нярав зэрэг 80 хүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулж чадавхжуулсан. Сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгуулж, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 186 | | 6.1.5.2. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх цахим сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлэх | | Сургалтад хамрагдсан хүний тоо Амьдралын чанарын өсөлтийн хувь | 15000 2 | | Багш, удирдах ажилтны арга зүйг, дээшлүүлэх ажлын хүрээнд Насан туршийн боловсролын багш, удирдах ажилтнуудын баруун бүсийн сургалт зөвлөгөөнд сумдын багш, менежерүүд нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй оролцож мэдлэг чадвар, туршлага судалсан юм. Сургалт, арга хэмжээгээр боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, насанд хүрэгчдийн сургалтын арга зүй сэдвээр зохион байгуулсан нь багш нарын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагаа болсон юм.Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар авахад мэдлэг чадвар олгох сургалт 2 үе шаттайгаар зохион байгуулсан ба эхний үе шатанд насан туршийн боловсролын төв, нэгжийн 26 багш нарт “И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадварын газраас 2023 оны 10 дугаар сарын 23,24-ны өдрүүдэд нийт 6 цагийн сургалтыг онлайнаар зохион байгуулсан. Сургалтаар цахим ур чадвар ба тоон бичиг үсэг, сошиал, интернэт хэрэглээ, гар утасны тохиргоо, видео хичээл, түүний талаарх ойлголт, дадлага хичээл гэх мэт агуулгыг хамруулсан юм. Тус сургалтад хамрагдсан 23 нэгжийн багш нар 25-45 насны 10-аас доошгүй иргэдэд 30 цагийн сургалтыг зохион байгуулсан ба нийт 352 хүнд хамрагдсан. Тус зорилтын хүрээнд Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан цахим ур чадвар олгох | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг 25-45 насны 51 иргэдэд зохион байгуулсан. Мөн Баянхонгор сумын багуудаас 51 иргэнийг тус бүр 6 цагийн сургалтад хамрагдсан. 2023 онд нийт 499 хүнийг сургалтад хамруулсан. | |
| 187 | | 6.1.5.3. Төрийн албан хаагч, иргэдийн үндэсний бичгийн чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах | | Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын түвшин | ахисан | | Аймгийн Засаг даргын “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах зардал олгох тухай” 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/273 дугаар захирамжийн дагуу "Үндэсний бичгийн олимпиад"-ыг зохион байгуулах удирдамж, “Хос бичигтэн төрийн байгууллага шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай" А/274 дүгээр захирамжийг удирдамжийн хамт төрийн болон төрийн өмчийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг сайжруулах, албан хэргийг үндэсний бичгээр хөтлөх, орчин хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Дэмжигч багш” ажиллуулах, хамтран ажиллах тухай Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 245 дугаар албан бичгийн хүрээнд монгол хэл, бичгийн 46 багшийг байгууллагуудад хуваарилан, хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна. 1. Хос бичигтэн төрийн байгууллага шалгаруулах болзолт уралдааны үе шат бүрийг хангаж, тайлан мэдээг цаг тухайд нь ирүүлсэн 16 байгууллага, 2 сумын тайлантай танилцаж, оноожуулсан бөгөөд аймгийн төвийн тайлан сайн бичигдсэн 5 байгууллагаар биечлэн орж, танилцаад комиссын дүнг нэгтгэж, эхний 5 байрыг шалгаруулан, урамшууллаа. Албан хэвлэмэл хуудасны эх бэлтгэх, хянах, олгох ажлыг Төрийн архивын тасагтай хамтран, аймгийн Засаг даргын А/604 захирамжийг хэрэгжүүлэн 180 байгууллагын албан бланкыг олгож дуусгалаа.Төрийн байгууллагын албан хаагчдын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дунд зохион байгуулсан “Үндэсний бичгийн олимпиад”-ыг 3 үе шаттай зохион байгууллаа. Олимпиадад 23 байгууллагын шилдэг албан хаагчид оролцож, онол, цахим бичвэрийн чадвараараа өрсөлдлөө. Уншлага, бичлэгийн уралдаанд 15 байгууллагын 600 гаруй албан хаагчид байгууллагаараа идэвхтэй оролцлоо. | |
| 188 | | 6.1.5.4. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт, төсөвлөлт" явуулын сургалт, сурталчилгааг дэмжих | | Сургалт, сурталчилгаанд хамрагдсан шийдвэр гаргагч, төрийн албан хаагчдын тоо | 150 300 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 3,0 сая төгрөг | Жендэрийн үндэсний хороо, аймгийн салбар зөвлөл хамтран 5 аймгийн 30 албан хаагчийг хамруулан анхан шатны сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, аймаг тус бүрээс 2, Баянхонгор аймаг 9 сургагч бэлтгэж, чадавхжуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлт, төсөвлөлт сургалтад тусгайлсан чиг үүргийн цэргийн анги, шүүх, цагдаа, онцгой байдлын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 35-40 албан хаагчдыг хамруулан чадавхжуулсан. Жендэрийн үндэсний хороотой хамтран жендэрийн сургагч 9 багшийг бэлтгэсэн. Өлзийт, Баян-Овоо, Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар, Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн албан хаагчдад сургагч багш нар 2 баг болж, сургалт зохион байгуулахаар төлөвлөж, хөтөлбөр, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэн зохион байгуулсан. 2023 онд нийт жендэрийн сургалтад 180 төрийн албан хаагч, 11 шийдвэр гаргагч хамрагдсан. | 70% |
| 189 | | 6.1.5.5. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол олгох | | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 60 10000 | | Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны А/471 дүгээр захирамжийн дагуу “Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилж, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсрол олгох" сургалтыг 20 сумын хэмжээнд зохион байгуулж, 3700 гаруй малчид, 2900 гаруй төрийн албан хаагч, 2200 гаруй сурагчид нийт давхардсан тоогоор 8800 гаруй хүн хамрагдсан байна. Сургалтаар байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл өгч, боловсрол олгосон. Мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээр 15 төрлийн 1025 ширхэг гарын авлага, цахим мэдээллийг бэлтгэж 77251 хандалт авсан байна. | 100% |
| 190 | | 6.1.5.6. Хэрэглэгчийн | | Хэрэгжилтий | 100 | Орон нутгийн | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагчийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрхийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд эрх зүйн боловсрол олгох аян зарлах, эрх зүйн сургалт зохион байгуулах | | н хувь | | төсөв | төлөвлөгөө боловсруулан Аймгийн Засаг даргын 2023 оны А/25 дугаар захирамжаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Олон Улсын өдрийг угтан аж ахуйн хэрэглэгчдэдээ ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ аян зарлаж аяны хүрээнд Баянхонгор Эрчим хүч ХХК, Дурсамж принт ХХК, Накула ресторан лоунж, Жинчин, Арвин булаг тал ХХК, Монхангай ХХК-ны Миний сүлжээ дэлгүүр зэрэг 6 байгууллага нэгдэж хэрэглэгчдээ зориулан хүнс, бараа бүтээгдэхүүн үйлчилгээндээ хямдрал урамшуулалт үзүүлж тайлан мэдээг ирүүлж хамтран ажилласан. Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголт хандлагыг бий болгох, иргэд, аж ахуйн нэгж эрхлэгчдэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын талаарх нэгдмэл ойлголтыг өгөх, бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтийг хангаж байгаа эсэхийг шалган тогтоох зорилгоор “Хүний эрх ба Хэрэглэгч таны эрх” сургалтыг Баянхонгор аймгийн Баянхонгор сум, Өлзийт, Баянговь, Баянлиг Богд, Жинст, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг зэрэг 11 сумын 900 гаруй аж ахуйн нэгжийн эзэд, төрийн албан хаагч, хэрэглэгчдэд эрх зүйн боловсрол олгох эрх зүйн сургалт зохион байгуулж гарын авлага тарааж ажиллав. | |
| 191 | | 6.1.5.7. Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн албаа хааж буй дайчиддаа хүндэтгэл үзүүлэх, цэрэг иргэний харилцааг бэхжүүлэх арга хэмжээ зохион | | Хэрэгжилтий н хувь | 250 | Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 15.0 сая төгрөг | Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат, Цэргийн штабын дарга хурандаа Г.Нэмэхбаяр болон аймгийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын гишүүд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах зорилгоор тус аймгаас 2022 оны II ээлжээр татагдан Зэвсэгт хүчний 339, 256, 017, 032, 326 дугаар ангиудад алба хааж буй дайчдаа 2023 оны 04 дүгээр сарын 03, 05 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд тус тус эргэх ажлыг зохион байгууллаа. Энэ үеэр аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат 2022-2023 оны хугацаанд аймагт хийгдэж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | | байгаа бүтээн байгуулалт, өвөлжилт, хаваржилтын талаар цэргүүдэд мэдээлэл өгч, Политехникийн коллежид мэргэшүүлэх, мэргэжилтэй болгох чиглэл дээр аймаг анхаарч дэмжиж ажиллахаа илэрхийлэн алба хаагч бүрд гарын бэлэг гардуулсан. Хилийн цэргийн 0166 дугаар ангид 2023 оны I ээлжээр татагдан хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг, дайчдаа эргэж аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулан өгч, цэргийн албаны үйл ажиллагаатай нь аймгийн Засаг даргын орлогч, аймгийн ЗДТГ-ын дарга нар танилцсан. Мөн Цэргийн гавьяаны одонт Хилийн 0166 дугаар ангийн түүхт 90 жилийн ойн баярын арга хэмжээнд оролцсон. | |
| 192 | | 6.1.5.8. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд эх оронч үзэл, хүмүүжил олгох урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | 300 | Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр 4.758.460 | Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Баянхонгор аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу ерөнхий боловсролын сурагчид, иргэд олон нийтэд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, цэрэг-эх оронч хүмүүжил олгох, Монгол цэргээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжил олгох цэрэг-спортын “Дөл” тэмцээн, “Энхийг сахиулагчдын өдрийн-Нээлттэй хаалга”-ны өдөрлөг, “Бидний бахархал” төсөл зэрэг ажлуудыг зохион байгуулан явуулсан. Нийт аймгийн хэмжээнд 288 хүүхэд оролцож, ажлын гүйцэтгэл 100 хувьтай. | 100% |
| 193 | | 6.1.6. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээний төвд MSJ архивын тоон систем нэвтрүүлэх | | Үйлчлүүлэгчдийн тоо | 10000 | Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 8.0 сая төгрөг | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12/54 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний 6.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Аймгийн Засаг даргын 2023 оны А/176 дугаар захирамжаар Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээний төвд үйл ажиллагаа хяналтыг сайжруулах, архивын тоон систем нэвтрүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Лавлагаа мэдээллийг чирэгдэл, дараалал үүсгэхгүй дугаараар үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн. | 70% |
| 194 | 6.1. Ухаалаг Засаглал | 6.1.7. Гамшгаас хамгаалах “Иж | | Зохион байгуулсан | 10, 80 | Засаг даргын нөөц хөрөнгө | Аймгийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Гамшгаас хамгаалах дадлага, сургууль | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүрэн”, команд штаб, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | | үзлэгийн тоо, Оролцооны хувь | | | зохион байгуулах тухай” А/191 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 4 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд Жинст, 2023 оны 10 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Баянбулаг сумдад тус тус гамшгаас хамгаалах “Иж бүрэн” дадлага, сургууль, 2023 оны 4 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Шинэжинст, 2023 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Бөмбөгөр сумдад тус тус гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын дадлага, сургууль, Гурванбулаг, Баянцагаан сумдад “Бэлэн байдлын үзлэг”-ийг тус тус зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд “Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургууль”-ийг 2 удаа 600 гаруй ажилтан, албан хаагч, “Команд штабын сургууль” 2 удаа 300 гаруй ажилтан албан хаагч, “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг 2 удаа 100 удирдах албан тушаалтан, “Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалт”-ыг 28 удаа 2587 сурагчдад “Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт”-ыг 50 удаа 854 ажилтан албан хаагч, “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт”-ыг 8 удаа 230 алба хаагч, “Иргэний сургалт” 22 удаа 830 иргэнийг тус тус хамруулан “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Мэргэжлийн ангийн дүрэм”, “Газар хөдлөлт”, “Галын аюулгүй байдал”, “Аюулгүй амьдрах ухаан”, “Бэлэн бай” багцаар танхимын болон дадлага сургуулийг зохион байгуулсан. Тус онд нийт 132 удаагийн сургалтаар 5022 гаруй ажилтан албан хаагч, сурагч, иргэнийг хамруулан гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулсан. | |

___oOo___